

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН  
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 7 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР  
/ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-15
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	16-59
	1.“Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	17-18
	2.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 12 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	18-26
	3.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2021.06.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	26-42
	4.“Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	42-48
	5.Батлагдсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга танилцуулах	48-54
	6.Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа	54-59

**Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы  
7 дугаар сарын 08-ны өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн  
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газраас Гамшгаас хамгаалах тухай хуулийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааныг цахим хэлбэрт шилжүүлж, Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын дэд дарга Т.Аюурсайхан, С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн, Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Д.Ганбат, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Баттөмөр, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Дамдинням, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Н.Учрал, Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга М.Оюунчимэг, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Б.Чойжилсүрэн, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Ганбаатар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, Ц.Анандбазар, Т.Аубакир, Ё.Баатарбилэг, Ж.Батжаргал, Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Б.Бейсен, Х.Булгантуяа, Г.Ганболд, Ц.Мөнхцэцэг, Н.Наранбаатар, Д.Өнөрболор, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Б.Саранчимэг, Г.Тэмүүлэн, Ж.Чинбүрэн, Б.Энх-Амгалан, Т.Энхтүвшин нар “Их хуралдай” танхимаас, бусад гишүүд MyParliament программ болон цахим хуралдааны программыг ашиглан чуулганы нэгдсэн хуралдаанд цахимаар оролцов.

Хуралдаанд ирвэл зохих 74 гишүүнээс 42 гишүүн цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлж, 56.8 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 04 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Х.Болорчулуун, Н.Ганибал, Х.Нямбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Сүхбаатар.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж үг хэлэв.

***Нэг. “Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга О.Номинчимэг, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Б.Пүрэвдорж танилцуулав.

Дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.*

**Г.Занданшатар:** “Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	39
Татгалзсан:	15
Бүгд:	54

72.2 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 10 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт нарын 12 гишүүн 2021.07.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга О.Номинчимэг, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа, Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нар “Их хуралдай” танхимаас тус тус танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Ц.Даваасүрэн, Н.Наранбаатар нарын тавьсан

асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт “Их хуралдай” танхимаас хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.*

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 51

Татгалзсан: 12

Бүгд: 63

81.0 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 10 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Зохихсүрэн, Үндэсний хөгжлийн газрын дарга Х.Батжаргал, мөн газрын дэд дарга Б.Дөлгөөн, Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга Г.Батхүрэл нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга О.Номинчимэг, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их

Хурлын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Ж.Ганбаатар нар “Их хуралдай” танхимаас тус тус танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, С.Чинзориг, С.Бямбацогт, Н.Учрал, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Зохихсүрэн, Үндэсний хөгжлийн газрын дарга Х.Батжаргал, Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга Г.Батхүрэл нар “Их хуралдай” танхимаас тус тус хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.*

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аялал жуулчлалын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нялх, балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах

тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хэмжил зүйн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 55

Татгалзсан: 11

Бүгд: 66

83.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 11 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.*

***Дөрөв. “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга О.Номинчимэг, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул нар байлцав.

Тогтоолын төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг “Их хуралдай” танхимаас танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ж.Бат-Эрдэнэ, Ё.Баатарбилэг, Б.Пүрэвдорж, Б.Баттөмөр нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ж.Мөнхбат “Их хуралдай” танхимаас хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.*

**Г.Занданшатар:** “Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 50

Татгалзсан: 16

Бүгд: 66

75.8 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

*Уг асуудлыг 11 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.*

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нарын гишүүдээс өргөн мэдүүлсэн Жендэрийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслөө татан авах саналыг Улсын Их Хуралд ирүүлснийг танилцуулав.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т заасны дагуу хууль санаачлагч төслөө татан авсанд тооцлоо./11:54/

Мөн Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын гишүүдээс Цөлжилтөөс сэргийлэх, ногоон хөгжлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах чиглэлээр лобби бүлэг байгуулах тухай албан бичиг ирүүлснийг танилцуулав.

***Тав.Батлагдсан хууль, Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга танилцуулах***

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар дараах хууль, тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Үүнд:

1.Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг эцсийн найруулгатай холбогдуулан санал хэлэв. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:55/

***Дагалдан гарсан:***

2.Хөдөлмөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг эцсийн найруулгатай холбогдуулан санал хэлэв. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:56/

3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:56/

4.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:56/

5.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

6.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

7.Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

8.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

9.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

10.Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

11.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

12.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:57/

13.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:58/

14.Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:58/

15.Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн



найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:58/

16.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:58/

17.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:59/

### ***Холбогдуулан боловсруулсан:***

18.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:59/

19.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:59/

20.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:59/

21.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:59/

22.Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:59/

23.Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./11:59/

24.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:00/

25.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:00/

26.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:00/

27.Кино урлагийг дэмжих тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:00/

***Дагалдан гарсан:***

28.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:00/

29.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:00/

30.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:00/

31.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:00/

32.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:01/

33.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:01/

34.Соёлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:01/

***Дагалдан гарсан:***

35.Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:01/

36.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:01/

37.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:01/

38.Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:01/

39.Гэр бүлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:01/

40.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:01/

41.Номын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:02/

42.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:02/

43.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:02/

44.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:02/

45.“Хуулийн төсөл буцаах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:02/

46.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:02/

47.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:02/

***Дагалдан гарсан:***

48.Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:02/

49.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:03/

50.Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:03/

51.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:03/

52.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:03/

53.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:03/

54.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:03/

55.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:03/

56.Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:03/

57.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:03/

58.Нийслэл хотын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:04/

59.Монгол Улсын автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:04/

60.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:04/

61.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:04/

62.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:04/

63.Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:07/

64.“Хот байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:04/

***Холбогдуулан боловсруулсан:***

65.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:05/

66.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:05/

67.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:05/

***Дагалдан гарсан:***

68.Төсвийн зарим тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, мөрдөх хугацааг хойшлуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:05/

69.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:05/

70.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:05/

71.Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд хуулийн эцсийн найруулгатай танилцлаа./12:05/

72.“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:06/

73.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:06/

74.“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:06/

75.“Үндсэн хуулийн цэцийн гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:06/

76.“Прокурорын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:06/

77.“Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:06/

78.“Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:06/

79.“Монгол Улсын Их Хурлаас албан тушаалтныг томилохтой холбогдуулан томилгооны сонсгол зохион байгуулах журам батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:07/

80.“Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:07/

81.“Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:07/

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн нарын гишүүдээс “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай бол санал боловсруулж, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хорооны хугацааг сунгасныг мэдэгдсэн албан бичиг ирүүлснийг танилцуулав.

*Уг асуудлыг 12 цаг 08 минутад хэлэлцэж дуусав.*

**Зургаа.Монгол Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа**

Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы хаалтын ажиллагаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Тамгын газрын Тэргүүн дэд дарга О.Номинчимэг, мөн газрын дэд дарга Э.Баттулга, Дотоод аудитын албаны дарга бөгөөд дотоод аудитор Я.Баттогтох, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Бямбадулам, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Б.Эрдэнэбилэгт, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга С.Янжинхорлоо, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Эрдэнэсамбуу, Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Ж.Сайнхишиг, Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга Б.Лхагвасүрэн, Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга С.Батбаатар, Парламентын судалгааны хүрээлэнгийн захирал Т.Баярмаа, Улсын Их Хурлын даргын Ажлын албаны ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Нийгмийн бодлогын зөвлөх Ц.Цогзолмаа, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн Ажлын албаны дарга С.Далхаасүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганыг хааж үг хэлэв.

Үг хэлж дууссаны дараа танхимд Төрийн дуулал эгшиглэхэд Улсын Их Хурлын гишүүд болон хаалтын ажиллагаанд оролцогсад босож хүндэтгэл үзүүлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы хаалтын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 6 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан нарийн бичгийн дарга Г.Нямсүрэн, Хуралдаан зохион байгуулах хэлтсийн шинжээч Э.Сувд-Эрдэнэ нар болон техник хангамжийн зохион байгуулалтыг Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, мөн хэлтсийн референт Ч.Алтантөр, шинжээч Б.Эрдэнэбаяр нар хариуцан ажиллав.

*Хуралдаан 2 цаг 23 минут үргэлжилж, 74 гишүүнээс 69 гишүүн хүрэлцэн ирж, 93.2 хувийн ирцтэйгээр 12 цаг 27 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН  
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 7 ДУГААР САРЫН 08-НЫ ӨДӨР  
/ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Засгийн газар, Улсын Их Хурлын гишүүд онцгой нөхцөлд хэрэглэгдэх хуралдааны дэгд заасны дагуу цахим программ ашиглан ирцээ бүрдүүлж нэгдсэн хуралдаанд цахимаар оролцож байна. 42 гишүүн чуулганы хуралдаанд оролцож байна. 11 гишүүн танхимд хүрэлцэн ирсэн байна. Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы 7 дугаар сарын 8-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулна.

Нэг.“Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Хоёр.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт нарын гишүүн өргөн мэдүүлсэн/

Гурав.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хувьд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хан дүрэн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар өргөн мэдүүлсэн/

Дөрөв.“Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл.

Тав.Батлагдсан хууль, Улсын Их Хурлын тогтоолуудын эцсийн найруулга сонсоно.

Зургаа.Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулганы хаалт болно.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Монгол Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдоржоос худам Монгол бичгээр гаргацтай сайхан бичсэн бичгийг ирүүлсэн байна. Болохгүй. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу “Улсын Их Хурлын даргад чуулганы урд өдрийн 5 цагаас өмнө бичиг ирүүлнэ” гэсэн 5 цагаас өмнө энэ худам Монгол бичгээр:

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танаа,

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж миний бие 2021 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх асуудалтай холбогдуулан үг хэлэх саналтай байгаа тул шийдвэрлэж өгнө үү.

Бөхчулууны Пүрэвдорж гэж 7 сарын 6-нд бичсэн ийм Монгол бичгээр бол их сайн бичсэнийг онцлон тэмдэглэе .Каллиграф маягтай бичсэн байна шүү. Ингээд эрхэм гишүүн Бөхчулууны Пүрэвдорж хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлнэ.

**Б.Пүрэвдорж:** Уржигдар бичсэн хүсэлт байгаа. Тэгэхээр яг энэ Төрийн өмчийн, ялангуяа стратегийн ордыг эзэмшдэг Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн

орлого, зарлагын гүйлгээ, ирэх жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Улсын Их Хурал, Засгийн газраас төсөв хэлэлцэхдээ хамтад нь оруулж ирэх тогтоолын төслийг миний бие санаачлаад өргөн барьсан.

Үүнийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулахгүй байж магадгүй гэж үзээд 6-ны өдөр бичсэн зүйл маань. Тэгэхээр өнөөдөр энэ хэлэлцэх асуудлын дарааллын эхний жагсаалтад оруулсанд их баярлалаа.

Тэгэхээр энэ хаврын чуулган бол миний хувьд маш үр дүнтэй боллоо. Үнэхээр шатахууны хэдэн жил ярьсан хуурамч шатахууны эсрэг хуулийг баталж гаргаж, хүн ардынхаа эрүүл мэнд, дээрээс нь эд хөрөнгө хамгаалах энэ чухал үйлст хувь нэмэр орууллаа. Энэ дээр ялангуяа өнөөдрийн олонх болсон Монгол Ардын намын гишүүдийн хийсэн ажил гэдгийг бас онцолж хэлэх хэрэгтэй. Яагаад гэвэл олонх энэ хуулийг дэмжсэн учраас л энэ хууль энэ парламентыг давж гарсан гэдгийг хэлье.

Ирэх намрын чуулганаар тэтгэврийн хэмжээ тогтоохдоо 5 жилийн дундаж байсныг 7 жилийн дундаж болгож уртасгасан. Үүнийг буцааж 5 жил болгох хуулийн төслийг хэлэлцүүлж батлуулах ажилд манай Ардын намын бүлэг, Ардчилсан намын бүлэг хамтарч зүтгэнэ гэж найдаж байна.

Ингээд сайхан зусаарай гэж ард түмэндээ хэлье.

**Г.Занданшатар:** Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Одоо хэлэлцэх асуудалд орно.

**“Монгол улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Төсвийн зарлагын дэд хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын эрхэм гишүүн, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны дарга Бөхчулууны Пүрэвдорж танилцуулна.

**Б.Пүрэвдорж:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2021 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар “Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хууль тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.7 дахь хэсэгт заасны дагуу Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос “Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл, баталсантай холбоотой авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулан нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан саналд үндэслэн тогтоолын төсөлд тусгасан арга хэмжээг Засгийн газраас авч хэргүүд хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, төсвийн сахилга бат,

хариуцлагыг сайжруулах, мөн төрийн өмчит хуулийн этгээдийн нийгмийн хариуцлагын хүрээнд зарлага, санхүүжилт гаргах харилцааг зохицуулах, ногдол ашиг төвлөрүүлэх бодлогыг боловсронгуй болгож, төсвийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг шинэчлэхтэй холбогдсон шийдвэрийн төслийг Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаас өмнө өргөн мэдүүлж хэлэлцүүлэх, Монгол Улсын Үндсэн хуулиар улсын төсөв батлах нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хадгалагдсан байх тул төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжсэн үйл ажиллагааны зарлагыг төсвийн бүрэлдэхүүн хэсэгт тооцож, уг арга хэмжээг хэрэгжүүлэхдээ Улсын Их Хуралд танилцуулж шийдвэрлүүлэх асуудлыг төсөлд тусгалаа.

Тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж, тогтоолын төслийг батлуулахыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

“Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоолын төслийг баталж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу. Алга байна. Цахимаар алга байна. Дэд хорооны саналаар “Монгол улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Эхлээд бүртгэлийн санал хураана. Одоо санал хураалт. Тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт. Туршилтын санал хураалт. За ирцэд ороогүй гишүүд ирцдээ ороорой. Ширнэнбандийн Адьшаа гишүүн яасан бэ. Норовын Алтанхуяг гишүүн, Дамбын Батлут, Балжиннямын Баярсайхан, Сайнхүүгийн Ганбаатар, Дашдондогийн Ганбат, Хассуурийн Ганхуяг, Цэрэнпилийн Даваасүрэн, Гонгорын Дамдинням, Борхүүгийн Дэлгэрсайхан, Оюунчимэг гишүүн ээ таных ирцэд ороогүй байгаад байна шүү. Батсүхийн Саранчимэг, Жамъянхорлоогийн Сүхбаатар, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан нар алга. Ингээд санал хураалт.

39 гишүүн дэмжиж, 72.2 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл батлагдлаа.

Дараагийн асуудалд орно.

**Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон засгийн газрын тухай хуульд**

**нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын эрхэм гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

Сандагийн Бямбацогт гишүүнийг индэрт урьж байна.

**С.Бямбацогт:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт, Адьшаа, Анужин, Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Булгантуяа, Ганболд, Доржханд, Мөнхбат, Оюунчимэг, Ундрам, Чинзориг нарын 12 гишүүн Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Монгол Улсын Их Хурал Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн баталсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийн байдлыг судлах, шаардлагатай санал боловсруулах үүрэг бүхий Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хэсгийг 2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн Улсын Их Хурлын даргын 51 тоот захирамжаар байгуулж, улмаар Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Улсын Их Хурлын 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолыг баталж, түүний хүрээнд энэ төслийг боловсруулсан. Төсөлд дараах зүйлсийг тусгалаа.

Нэгдүгээрт. Төлөвлөлтөд суурилсан зарчим, энэ хуулийн 6.9-д заасан богино хугацааны төлөвлөлтийн баримт бичиг болох улсын болон орон нутгийн төсөвт төлөвлөхдөө 6.16.14-т заасан шаардлагыг хангаж, Улсын болон аймаг, нийслэлийн хотын хөгжлийн төлөвлөгөөнд суурилан боловсруулах зарчмыг оруулсан.

Хоёрдугаарт. Нэгтгэн тайлагнах зарчим. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг Улсын Их Хуралд аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг иргэдийн хуралд тайлагнахдаа тус хуулийн 6.7, 6.8-д заасан баримтад заасан зорилго, зорилт, хүрэх үр дүнг уялдуулан төлөвлөж, тухайн жилд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь хүрэх, үр дүнгийнхээ хувьд хэдэн хувьд хүрсэн хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийн талаарх мэдээллийг нэгтгэн, баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу хамтад нь тайлагнахаар төсөлд нэмж тусгалаа.

Гуравдугаарт. Хөгжлийн бодлого төлөвлөх, баримт бичгийг боловсруулахдаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, хэлэлцэн батлах, тайлагнах цагалбаруудыг төсвийн цагалбартай уялдуулж, Улсын Их Хурал жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, хянан хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл дараа жилийн улсын хөгжлийн төлөвлөгөөний төслийг боловсруулах асуудлаар, эсвэл холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох асуудлаар Засгийн газар чиглэхээр тогтоолын төсөл тусгасан.

Дөрөвдүгээрт. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гэж Засгийн газрын үйл ажиллагаа, хөтөлбөрийн зорилго,

зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсөл, арга хэмжээ, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн бичиг баримт байхаар тооцлоо.

Эдгээр асуудлыг тусгасан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг Их Хурлын нэр бүхий гишүүд санаачилсан.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын эрхэм гишүүн Баагаагийн Баттөмөр танилцуулна.

Баттөмөр гишүүний индэрт урьж байна.

**Б.Баттөмөр:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт, Адьшаа, Анужин, Баттөмөр, Бат-Эрдэнэ, Булгантуяа, Ганболд, Доржханд, Мөнхбат, Оюунчимэг, Ундрэм, Чинзориг нарийн гишүүд 2021 оны 7 дугаар сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Монгол Улсын урт, богино, дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн төсөл боловсруулах, үйл ажиллагааг ойлгомжтой болгох, түүнчлэн урт, дунд, богино хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад тавигдах шаардлага, зарчмыг сайжруулах талаар зохицуулалтыг тусгасан бөгөөд төслийн хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр хөгжлийн бодлого боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн бодлогын харилцан уялдааг хангах, салбар дундын болон орон нутгийн бодлогыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгуулах асуудлыг тусгажээ.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн Улсын Их Хурал, Засгийн газрын бодлого нь Засгийн газрын бодлого төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн шатанд ёс зүйтэй байх, мэргэжлийн болон сургалтын чиглэлээр ажиллах боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Чинзориг, Засгийн газрын тухай хуулийн өөрчлөлт оруулах тухай хуулийг өргөн хүрээнд авч үзэх, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дэргэдээ судалгааны байгууллагатай байх талаар асуулт асууж, санал хэлж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа. Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүнээр тасаллаа. Цахимаар 1 гишүүнээр тасаллаа. 2 гишүүнээр тасаллаа.

Эрхэм гишүүн Бямбасүрэнгийн Энх-Амгалан асуулт асууна.

**Б.Энх-Амгалан:** Монгол Улсын хөгжлийн бодлого, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулахыг бол дэмжиж байгаа юм. Хуульд өөрчлөлт оруулах үндэслэл нь болохоор Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлт хоорондоо уялдаатай, тэдгээрийн нийцлийг хангаж, хуулийн давхардал, хийдэл зөрчил үүсгэхгүйгээр зохицуулахаар орж ирж байгаа юм байна. Би зүйл дээр асуулт асуух гээд байгаа юм. Хөдөөгийн хөгжлийнхөө бодлогыг энэ дээр давхардсан юмнууд байна уу? Газар тариаланг эрчимжүүлэх, усалгаатай тариалангуудыг нэмэгдүүлэх, үр тариаг авах энэ тэр асуудал дээр малынхаа үйлдвэр угсааг сайжруулах, 1 малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх, таваарлаг чанарыг нь сайжруулах тал дээр. Энэ дээр ямархуу асуудлууд байна. Бүс нутгийн хөгжлийн бодлого маань энэ дээр хэр уялдаж байгаа вэ гэдэг асуулт асуух гэсэн юм.

**Г.Занданшатар:** Хууль санаачлагч эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт асуултад хариулна.

**С.Бямбацогт:** 2019 онд Монгол Улсын Их Хурал Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлахдаа Монгол Улсын хөгжлийн бодлогод нийцүүлсэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөө, Улсын төсвийг энэ бодлогын бичиг баримтыг бүгдийг нь ерөөсөө урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглүүлнэ гэж заасан. Үүнтэй холбоотойгоор хөгжлийн бодлого төлөвлөлт тогтвортой байна гэж Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт орсон.

Үүний дагуу хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баталсан. Үүгээрээ Улсын Их Хурлаар маш олон төрлийн бодлого хөтөлбөр, хууль гээд олон бодлогын бичиг баримтуудыг баталдаг байсан бол үзэл баримтлал үүнийг цэгцэлж байгаа. Урт хугацааны хөгжлийн бодлого буюу алсын хараа 2050 дунд хугацааны хөтөлбөр буюу 7 хөгжлийн зорилт хөтөлбөр, мөн Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл. Богино хугацаандаа Монгол Улсыг хөгжүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. Богино хугацаандаа бол Монгол

Улсын хөгжүүлэх жилийн төлөвлөгөө гэсэн ийм бодлогын бичиг баримтыг батлах. Үүнийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын төсөв болон бусад эх үүсвэрийг зохицуулахаар энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд заасан.

Яг таны ярьж байгаа асуудал бол үндсэндээ Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр. Монгол Улсыг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд бол тусгагдах асуудал. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль бол ерөнхийдөө хөгжлийн бодлогын бичиг баримтуудыг хэрхэн яаж боловсруулах вэ, түүнийг хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ, бодлого гэж юу юм, бодлогоо яаж төлөвлөх юм, түүнийг хэрхэн яаж зохион байгуулах юм, хэрэгжилт, үр дүнг нь яаж тооцдог байх юм гэдэг бодлогын асуудлуудыг зохицуулах ийм хууль.

Бодлогын бичиг баримтуудад Монгол Улсын эдийн засаг, нийгэм, засаглал, байгаль орчин, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил гэсэн асуудлыг бол Засгийн газрын үйл ажиллагаа хөтөлбөрт туссан. Энэ хүрээндээ хэрэгжүүлэх тал дээр Улсын Их Хурал бодлогын бичиг баримтаа баталж өгөөд Засгийн газар хэрэгжүүлж явахаар туссан байгаа. Тэгэхээр энэ хүрээндээ үндсэндээ бүс нутгийн болон үндэсний хэмжээний бодлогууд явна гэж та бас ойлгож байгаа.

**Г.Занданшатар:** Одоо цахимаар эрхэм гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн асуулт асууна.

**Ц.Даваасүрэн:** Та бүхэндээ энэ өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал дээр бас манай Их Хурлын гишүүд анхаараад ер нь мөрдөгдөхгүй явж байсан энэ байдлыг засъя, тодорхой хуулиудад нь өөрчлөлт оруулъя гэж байгааг би дэмжиж байгаа юм. Тэгэхээр бид нэг зүйлийг бодмоор байгаа юм л даа. Ер нь яагаад хуулиудтай байсан мөртөө урт хугацааныхаа төлөвлөлтийн бодлогыг дагахгүй яваад байсан юм бэ л гэдэг асуудал байгаа юм л даа.

Бусад оронд болоод байдаг манайд болоод байдаг уу? Үндсэн хуулийн өөрчлөлтөөр энийг шийдчихсэн гээд байгаа нь бол би бас тийм төгс шийдэл биш гэж үзэж байна.

Яагаад гэвэл өмнө Үндсэн хуульд заалт байсан юм. Хуулийг дээдэлнэ гэж хуулиуд дээр байсан шүү дээ. Бид нар урт хугацааны хөтөлбөрөө дагаж мөрдөж, сонгуулийн хуулиуд дээр намууд энэ хуулийн дагуу ингэж явна гэсэн мөртлөө энэ мөрдөгддөггүй. Том намууд нь зөрчөөд ороод ирдэг, тэгээд элдэв янз бүрийн том, том халамжийн амлалтууд орж ирээд батлагдчихдаг. Би 1 минутаа шууд нэмээд явчихъя. Тэгээд зөрчигдөөд байдаг байсан юм. Тэгэхээр Үндсэн хуульд ингэж тодотгосноор шийдэгдчихнэ гэж байгааг бол би итгэхгүй байна.

Ер нь юунаас болоод байна вэ гэвэл нэгдүгээрт бол энэ хуулийг, энэ төлөвлөлтийг ёстой дагаж мөрдөх ёстой юм биш үү гэдэг тийм хариуцлагатай хариуцлагаа ухамсарласан ийм ёс зүй улс төрчдөд байна уу гэдэг л асуудал байгаад байна. Ер нь энэ хуулийг сахина гэдэг чинь хүний ёс зүйтэй холбоотой.

Хоёрдугаарт мэдээж энийг ажил хэрэг болгочих мэргэжлийн баг бүтцийн асуудал байгаад байгаа юм. Бүтэц гэхээр манайд бол тийм яам байхгүй. Яамнаас гадна энэ чинь хүрээлэнгүүд институт байдаг. Энэ судалгааг нь хийдэг, энийг боловсруулдаг, төлөвлөлтийн бодлогыг тодорхойлоход оролцдог. Манай тэр бүтцүүд байхгүй байна гэж. Өөр нэг асуудал бол цаг хугацааны, цагалбарын

асуудлууд байгаа юм. Ингээд үндсэн чиглэл 5 жилээр хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг баталчихдаг. Гэтэл намууд нь 4 жилээр засаглаж байгаа шүү дээ. Тэгэхээр ер нь 4 жилийн дараа өөр нэг нам гараад ирлээ гэхэд энийг дагах болов уу, үгүй болов уу гэдэг асуудал байгаа шүү дээ.

Тэр нь тэгээд олонх болчихно. Магадгүй үнэмлэхүй олон болчих юм бол нөгөө цөөнх болсон 4 жил засаглагчаад тэгээд айж эмээгээд чадахгүй болчихно шүү дээ. Тэгээд л гадагшаа зугтчихдаг шүү дээ манайхан чинь. Тийм учраас энэ бол бас амьдралд жоохон үндэслэл нь ямар байна даа л гэдгийг бас энэ салбар дээр анхаараач гээд байгаа юм.

Тэгээд намууд байна. Ер нь намууд л сонгуульд оролцохдоо ард түмний сэтгэл зүйгээр яаж тоглох вэ гэдэг том амлалтуудыг л хийчихээд энэ чинь үймүүлээд байгаа шүү дээ. Тэгээд дараа нь гарч ирээд үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг батлахдаа урт хугацааны хөтөлбөртэй уялдуулж байна уу гэдэг чинь өөрөө худлаа асуудал болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр ер нь бол энэ цэвэр улс төрчдийн ёс зүйтэй л холбоотой асуудал болчихоод байгаа юм даа. Тэгээд Үндсэн хуулийн тэр өөрчлөлтөөр бүгдийг нь болчихно гэж байгаа нь бол би итгэхгүй байна.

Яагаад гэвэл Үндсэн хууль дээр хуулийг дээдэлнэ гэдэг заалт өмнө нь байсан мөртөө энэ чинь болоогүй юм гэж. Тэгэхээр ер нь боловсон хүчнээ бэлтгэе, тэгээд тэр бүтцийг нь бий болгоё гэж. Хуучин бол бүх салбарын мэргэжлийн, хамгийн өндөр түвшний улсууд бол төлөвлөлт бодлого тодорхойлдог тэр үндэсний төлөвтэй.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт асуултад хариулна. Ер нь гол нь чухал саналууд байна даа

**С.Бямбацогт:** Тэгэхээр төрийн бодлого тодорхойгүй, төрийн бодлого тогтворгүй, өнгөрсөн 30 жил явж ирсэн. Үүнийг засах гэж Үндсэн хуульдаа бид нар хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэсэн үг оруулсан. Бодлого тогтвортой байх юм бол үр дүн гардгийг 21 аймгийн хатуу хучилтай замаар холбох ажлыг эхлүүлээд Ардын нам, Ардчилсан нам гэхгүйгээр хэрэгжүүлж чадсан явдал.

Бодлого тогтворгүй байх юм бол 5 дугаар цахилгаан станц барихаас авхуулаад, төмөр замын асуудал мөн Улаанбаатар хотын агаарын бохирдолд. Нэг хэсэг нь шахмал түлш гээд л, нэг хэсэг нь хямд нүүрс гээд, нэг хэсэг нь утаагүй зуух гээд л. Ингээд бодлого дандаа өөрчлөгддөг байсан. Ингэхдээ яадаг вэ гэхээр Их Хурлаар, Засгийн газраар хуульчлаад баталчихдаг. Хуульчлаад баталчихсан юм чинь хуулийг дээдэлнэ гээд хууль зөрчөөгүй байдаг. Бодлого хөдлөх, бодлого тогтворгүй асуудлыг хуульчлаагүй байсан. Тийм учраас хөгжлийн бодлого тогтвортой байна гээд Үндсэн хуульд оруулсан учраас төрийн бодлогыг өөрчлөх юм бол Үндсэн хууль зөрчсөн Засгийн газар бол огцрох, хариуцлага тооцох асуудал үүснэ.

Яг үүнтэй адилхан бид нар хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуулийн 24.4-т хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд тусгасан үзүүлэлтүүдийг биелүүлэхийн төлөө ажиллахгүй бол төлөвлөлтийн баримт бичгийг зөрчих юм бол Засгийн газрыг, Сайдыг, Засаг даргыг огцруулах үндэслэл болно гээд оруулчихсан юм.



Ийм байдлаар үндсэндээ төрийн бодлого тогтвортой байх, төрийн бодлого тодорхой байх, хэрэгжих боломжийг Үндсэн хууль болон Үндсэн хуулиас урган гарч байгаа хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиар зохицуулж өгсөн. Мөн яагаад дунд хугацааны бодлогын бичиг баримт буюу 5 жилийн төлөвлөгөө байх ёстой юм бэ гэдэг нь 4 жилийн сонгуулийн циклтэй зориуд зөрүүлсэн юм. Ингэхгүй бол яг сонгуулийн циклээр л бодлого гардаг байх юм бол ялсан нам л өөрийн бодлогоо хэрэгжүүлнэ гэж явна. Тийм учраас зориуд зөрүүлж байж төрийн бодлогыг ялсан нам нь хэрэгжүүлдэг байх асуудлыг Үндсэн хууль бол энэ хуулиас суулгасан учраас төрийн бодлого залгамж чанартай, тогтвортой цаашид үргэлжлээд явах бололцоог бүрдүүлэн.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн нэмж тодруулж асууна.

**Ц.Даваасүрэн:** Би тодруулъя. Тэгэхээр Бямбацогт гишүүн ээ. Ялчихсан нам хөтөлбөрөө хэрэгжүүлнэ. Ард түмэнд амласан зүйлээ биелүүлнэ гээд л зүтгэж байна шүү дээ. Тэр бол зүгээр ойлгомжтой зүйл байхгүй юу. Ер нь бол хуулиуд дээр тодорхой хязгаарлалтууд байдаг. Ялангуяа тухайн сонгуулийн үр дүнгээр ялсан намын дарга нь Засгийн газрын тэргүүн хийчхэж байгаа. Тэгээд засгаа шийдэх асуудлаа өөрөө дангаараа шийдээд явчхаж байгаа. Энэ нөхцөлд бол наадах чинь худлаа л юм байгаа юм л даа зүгээр. Тэгээд бид нар ер нь хамгийн гол нь л энэ улс төрчдийн өөрсдийнх нь ёс, ялангуяа лидерийн, тэр намын лидерээс шалтгаалах болчхоод байгаа байхгүй юу. Төрийн 3 өндөрлөгөөс шалтгаалах асуудал болчхоод байгаа болохоос биш. Тэгээд наад цэц чинь яг цаг дээрээ болохоор шал худлаа байгаад байгаа шүү дээ. Тийм учраас ер нь юу л бол гэж. Би зүгээр Үндсэн хуульд орчихсон ингээд байж болохгүй гээд байна шүү дээ. Яагаад гэвэл Үндсэн хуульд хууль дээдэлнэ гээд байсан л байхгүй юу. Тэр заалтыг хэн авч орж ирж өнөөдөр ийм асуудлыг босгож ярьж.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Хууль санаачлагч, эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт хариулна.

**С.Бямбацогт:** Монгол Улсыг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлд 100 зорилт дэвшүүлсэн байлаа гэхэд сонгуульд оролцож байгаа намууд тэр 100 зорилтоос 5 жилийн хугацаанд жил жилдээ 20 гэж бодох юм бол түүнээс 80-ыг нь л сонгоно. Энэ 80-ыг бид нар энэ 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ гэж 100-аас. Түүнээс гадна 100-аас 101 дэх юм уу, 102 дахь зорилтыг дэвшүүлэх юм бол түүнийг Монгол Улсын Үндэсний аудит, Сонгуулийн ерөнхий хороо сонгуульд оролцохыг нь бүртгэхгүй. Ийм хуультай. Өөрөөр хэлэх юм бол 5 жилийн төлөвлөгөөнд суусан 100 зорилтоос л бид нар сонгуульд оролцохдоо 80-ыг нь энэ 4 жилийн хугацаанд хийж хэрэгжүүлнэ гэдэг зорилтоо тавиад, түүнийг нь бүртгэнэ. Түүнээс өөрийг дэвшүүлэх юм болбол бүртгэхгүй байх байдлаар төрийн бодлогыг тогтвортой байх, төрийн бодлого залгамж чанартай байх асуудлыг энэ хууль болон бусад хуулиудаар зохицуулсан. Ингээд 2020 оны сонгууль, 2016 оны сонгуульд оролцоод явж байгаа. Өөрөөр хэлэх юм бол энэ л зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө аль ч нам нь сонгуулийнхаа мөрийн хөтөлбөр дэвшүүлдэг. Түүнийг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Нанзадын Наранбаатар асуулт асууна.

**Н.Наранбаатар:** Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль өөрчлөлт орохоор хөгжлийн бодлогын баримт бичгүүд, үндсэн чиглэл, хөгжлийн төлөвлөгөө, төсөв, аймгуудын хөгжлийн баримт бичгүүд, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, энэ

зүйл эмхлэгдэж, цэгцлэгдэж нэг шугамд орох уу? Юу нь яг тодорхой өөрчлөгдөх юм бэ? Үндсэндээ аймгуудыг бүсчлэн хөгжүүлнэ гэж нэлээн хэдэн жил ярьсан боловч олигтой үр дүнд хүрсэнгүй. Энэ дээр бас асуулт асууя гэж бодсон юм. Тэгээд Эдийн засгийн хөгжлийн яам байгуулна гэж зорилт дэвшүүлж ярьсан. Тэгэхээр энэ асуудал энэ хуульд тусгагдаж орж байгаа юу гэсэн асуулт байна.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн, хууль санаачлагч Сандагийн Бямбацогт асуултад хариулна.

**С.Бямбацогт:** Их чухал асуулт асууж байна. Монгол Улсын Их хурал өнгөрсөн хугацаанд нийтдээ 560 гаруй бодлогын бичиг баримтууд баталсан байдаг юм. Байгаль орчны яам гэхэд л байгаль орчинтой холбоотой ой хамгаалах, ус хамгаалах, ан амьтан хамгаалах дахиад тэрийгээ бас өөр хэлбэрээр хөтөлбөр, үзэл баримтлал, бодлого гээд түүнийх нь дараа араас нь хууль гэдэг ч юм уу, ингэхдээ юу гэдэг юм, гаднаас төсөв санхүүжилт авахын тулд, эсвэл ажил хийсэн нэр зүүхийн тулд Улсын Их Хурлаар болон Засгийн газар маш олон бодлогын бичиг баримтуудыг батлуулсаар байгаад аймаг болгон яам болгон Засгийн газрууд маш олон бодлогын бичиг баримт баталсан. Тэрнийх нь зарим нь хүчингүй болчихсон. Зарим нь хоорондоо зөрчилтэй, уялдаагүй байсан асуудлыг цэгцэлж байгаа энэ хуулиар.

Өөрөөр хэлэх юм бол түрүүн хэлсэн ерөөсөө бодлогын бичиг, баримтууд Монгол Улсыг үндэсний хэмжээнд яаж хөгжүүлэх юм, бүс нутгийн хэмжээнд яаж хөгжүүлэх юм, орон нутгийн хэмжээнд яаж хөгжүүлэх юм гэсэн тодорхой салбарын болон салбар дунд нь яаж хөгжүүлэх юм, үүнийгээ урт болон дунд хугацаанд богино хугацаанд яаж харилцан уялдуулах юм гэдэг асуудлыг нь хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулиар зохицуулсан.

Яг үүнтэй энэ хуульд нийцүүлж урьд нь батлагдсан бүх бодлогын бичиг баримтуудыг хүчингүй болгох, шинэчилж батлах энэ ажлуудыг Засгийн газар хийж хэрэгжүүлэх ёстой. Дараагийн батлах, оруулж ирэх хуулиар Засгийн газрын өргөн барьсан хуулиар маш олон хуулиудыг энэ хөгжлийн бодлогын хуульд нийцүүлж хүчингүй болохоор орж ирж байгаа. Ийм байдлаар асуудлыг шийдэх юм.

Урьд нь төлөвлөгөөний комисс гэж бас байсан. 1990 оноос өмнө. Бүх бодлогыг тэнд зангиддаг байсан. Түүнтэй адилхан Япон улсад, Сингапур улсад, Солонгос улсад, Малайз улсад бас иймэрхүү жишигтэй энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн төрийн захиргааны төв байгууллага ажилладаг. Яг үүнтэй адилхан бас бүтэц байж энэ бодлогыг нэгтгэн зангидаж, нэгтгэж, удирдаж, төлөвлөж, зохион байгуулж, хэрэгжилт нь хяналт тавьж ажиллахгүй бол яам болгон аймаг болгон тус тусдаа өөрийн бодлого явуулна гэдэг нь Монгол төрийн бодлого тодорхойгүй, салангид, хэрэгжих боломжгүй, хяналт тавих.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Нанзадын Наранбаатар гишүүн 1 минут тодруулъя.

**Н.Наранбаатар:** Тодруулга алга байна.

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлсний дараа санал хураалт явуулна. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу. Эрхэм гишүүн Жамбалын Ганбаатараар тасаллаа. Цахимаар алга байна. Эрхэм гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Жамбалын Ганбаатар.

**Ж.Ганбаатар:** Баярлалаа. Өчигдөр Байнгын хороогоор уул нь Засгийн өргөн барьсан хууль нь эхлээд хэлэлцсэн юм л даа. Засгийн хууль дээр үндэслээд явсан бол уул нь их зүгээр байсан болов уу даа. Тэгээд гишүүдийн өргөн барьж байгаа хууль нь Засгийн өргөн барьж байгаа хуулиасаа энэ гол өөр агуулга нь бол яам байгуулна. Гол зүйл нь яам байгуулна. Шадар сайд энэ яамыг толгойлно. Тэгээд яамны эрх, үүрэг чиг энэ тэр бол их сайн гарсан. Цар хэмжээ бол их сайн гарсан. Энийг харин хэрэгжүүлэх ёстой. Бямбацогт гишүүн ээ би дэмжээд хэлээд байгаа юм. Дэмжээд хэлээд байгаа юм. Тэгээд даргын дэргэдэх зөвлөлийн дэргэд 15 хүнтэй ахиад зөвлөл байгуулна. Энэ бол харин бодууштай зүйл. Тэгэхдээ одоо мэдэхгүй. Хууль санаачлагч өөрөө их сайн гэж ойлгож байгаа учраас би бас сайн гэж ойлгоод байгаа. “Төрийн захиргааны байгууллага байна” гэснийг “Төрийн захиргааны төв байгууллага байна” гэж өөрчилж байгаа юм. За тэгээд мэдээж гишүүдийн өргөн барьсан хууль дээр Бямбацогт гишүүний хэлж байгаа сайн, сайн зүйлүүд бол орсон. Гэхдээ энэ хууль харин цаг үеэ олоод хэрэгжээсэй гэдэг дээр би бол санаа зовж байгаа. Даваасүрэн гишүүний хэлж байгаа мэргэжилтнүүд бид нарт байгаа юу, тасарчихсан уу? Үнэхээр эрх ямбаа, эрх ашгаа, эрэмбээ өөрөө мэдрээд яг улсынхаа төлөө бодлого төлөвлөлтөө хийж чадах болов уу гэж. Тэгээд яамнууд нь тэр яамандаа захирагдаад. Үнэхээр уул нь бол би дотроо юу гэж бодож байгаа вэ? гэхээр Засгийн аж ахуйн болоод чиглэлийн яамнуудад үнэхээр тус болох яам гэж ойлгож байгаа юм. Ихэнх ажлыг нь өмнөөс нь хийгээд өгчих юм байна гэж. Тийм учраас энэ хууль бас гишүүдийн өргөн барьж байгаа хууль дээр бол би дэмжиж үг хэлж байна аа гэдгийг хэлье. Тэгэхдээ яах вэ бусад асуудлуудыг нь бол Бямбацогт гишүүн ярьчихсан учраас би давхардуулж яриад яах вэ Бямбацогт гишүүн ээ тэ. Та ярьчихсан учраас. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ганбаатар гишүүн дэмжиж үг хэллээ. Гишүүд үг хэлж дууслаа. За одоо санал хураалт явуулна. Бүртгэлийн санал хураалт. Байнгын хорооны саналаар Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг болон хамт өргөн мэдүүлсэн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

51 гишүүн дэмжиж, 81 хувийн саналаар саналыг дэмжлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Ажлын хэсгээ байгуулаад ажилдаа орно.

Дараагийн асуудалд орно.

**Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.** Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга Цэндийн Нямдорж танилцуулна.

**Ц.Нямдорж:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

2021 оны 5 сард Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль батлагдсан. Энэ хуулийг батлах үндсэн нь Үндсэн хуулийн нэмэлтээр хөгжлийн бодлого тогтвортой

байна гэсэн заалт орсон. Тэрийг үндэслэсэн хууль байсан. Хууль батлагдсаны дараа 5 жилийн үндсэн чиглэл батлагдсан. Сая Улсын Их Хурлаас анхны жилийн төлөвлөгөө батлагдах шийдвэр гарч байна. Энэ хууль батлагдана гэдэг тооцоо өмнө нь Үндсэн хууль болон бусад хуулиудад байгаагүй. Шинэ хууль, заалт Үндсэн хуульд орж, шинэ хууль батлагдсан учраас өмнө нь гаргасан хуулиуд шинэ хуультай, зөрчилдөх нэр томъёоны хувьд, үг, үсгийн хувьд, хугацааны хувьд гэх мэт үзүүлэлтээр. Хууль хоорондын давхардал, зөрчил хийдэл гарсан учраас Улсын Их Хурал, Засгийн газарт даалгавар өгсөн. Энэ зөрчил арилгах арга хэмжээ ав гэж.

Энэ үндсэн дээр ажлын хэсэг байгуулагдаад 52 хуульд, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульд нийцүүлэн оруулах өөрчлөлтийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж Их Хуралд өргөн мэдүүлсэн. Энэ 52 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Байнгын хороогоор хэлэлцүүлж дэмжүүлсэн. Одоо Их Хурлын чуулганд танилцуулж байна.

Та бүхэн асуудлын мөн чанарыг ойлгож, холбогдох шийдвэрийг гаргаж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг эрхэм гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Жамбалын Ганбаатар танилцуулна.

**Ж.Ганбаатар:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 6 сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2021 оны 7 сарын 7-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч дунд хугацааны буюу 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг, богино хугацааны буюу 4 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт зарим өөрчлөлтийг оруулах, бодлогын баримт бичгүүдийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх, түүнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, субъектийн эрх үүрэг, бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдсан зарим нэр томъёог хуульд нийцүүлэх замаар хууль хоорондын зөрчил, давхардал хийдлийг арилгахын тулд хуулийн төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Баттөмөр хэлэлцүүлгийн явцад ажлын хэсгийг байгуулан хөгжлийн бодлого болон загвараа зөв тодорхойлж, хөгжлийн загвартаа баялгийн менежментээ зөв тодорхойлох, худалдааны яам байгуулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, дижитал эдийн засаг гэх мэт эдийн засгийн бодлогын шинэ асуудлыг суурьшуулах зэрэг асуудлыг тусгах, Улсын Их Хурлын гишүүн Чинзориг жилийн төлөвлөгөөг урт, дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулж Улсын Их Хурлаар хөгжлийн төлөвлөгөөг батлах хугацааг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй уялдуулж адил хугацаанд баталдаг болох, Хөгжлийн яам байгуулах асуудлыг хамтад нь шийдвэрлэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатар хувийн хэвшлийг дэмжиж, улсын хөгжлийг тодорхойлоод оролцдог байх эрх зүйн орчныг бүрдүүлэх, төр зөвхөн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт нь хяналт

тавьдаг тогтолцоо нь шилжих, хөгжлийн яамыг ойрын хугацаанд байгуулж, урт хугацаанд тогтвортой ажиллуулах, энэ чиглэлээр боловсон хүчнийг бэлтгэх, анхаарах шаардлагатай гэсэн саналуудыг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх хуулийн төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авто замын хуульд нэмэлт оруулах тухай, Агаарын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Барилгын хуульд өөрчлөлт оруулах тухай гэх мэт хуулиудад хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга Цэндийн Нямдорж. Сангийн сайд Болдын Жавхлан. Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга Нэргүйн Мягмар, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Пүрэвийн Зохицсүрэн, Үндэсний хөгжлийн газрын дарга Ханджавын Батжаргал, Үндэсний хөгжлийн газрын дэд дарга Баасандаваагийн Дөлгөөн, Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга Галсандоржийн Батхүрэл.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр тасаллаа. Цахимаар 2 гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Жигжидийн Батжаргал.

**Ж.Батжаргал:** Их Хурлын гишүүдийнхээ энэ өглөөний амар амгаланг айлтгая. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль бол их сайн хууль гарсан. Бид ер нь энэ хөгжлөө бас нэг зүг чигт харж төлөвлөлтийнхөө асуудлыг нэлээн зөв зохицуулж чадсан ийм хууль болсон. Энэ хууль дээр мэдээж бас тодотгох юмнууд байсан. Үүнийг манай Их Хурлын зарим гишүүд ч, Монгол Улсын Засгийн газраас ч хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар өргөн барьж орж ирж байгаа юм байна. Тийм учраас би энэ хуулийн төслийг үзэл баримтлалынх нь хувьд хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж дэмжиж байна. Энэ 2 төслийг хоёуланг нь хамтатгаж хэлэлцэх ёстой ингэж ойлгож байгаа. Мэдээж улс орны түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хийхдээ цаг хугацааных нь цагалбарын асуудлыг бид нэлээн бодох ёстой. Үүнийг би саяны төслөөр ороод ирж байгаа юм болов уу гэж ойлголоо. Төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөө 2 бол 1 цагалбартай, тэр төлөвлөгөөгөө хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрээ дайчилсан хэлбэрээрээ төсөв нь орж ирж байх нь зөв болов уу гэж ойлгож байна. Би ингэж ойлголоо.

Хоёрдугаарт. Аймаг сумдын түвшинд энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтийнх нь асуудлыг бас нэлээн эргэж хармаар юмнууд байгаа юм байна даа гэж ойлгогдоод байдаг юм. Ерөөсөө бид энэ төрийн албанд зохиомол ачаалал үүсгээд байгаа юм бол эмх замбараагүй баахан төлөвлөлтүүдээс болж үүдээд байгаа. Энэ аймаг, сумын түвшний, төрийн албан хаагчид чинь бол ер нь нэлээн сайн дарагдаж ажиллаж байгаа шүү. Тийм учраас үүнийг зөв зохицуулж, зөв авч явах тухай асуудал байгаад байгаа юм. Үүний талаар ер нь ямархуу бас. Жил гаран хэрэгжлээ энэ хууль. Тэгэхээр энэ хугацаанд судалгаа тооцоо хийсэн юм байна уу, яаж зохицуулахаар энэ нэмэлтэд орж ирэв гэдэг асуудал байна.

Дараагийн зүйл. Ер нь бид аль ч түвшиндээ дандаа бодлого.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Жигжидийн Батжаргал гүйцээж, асуултаа тодруулж асууна.

**Ж.Батжаргал:** Аль ч түвшиндээ, ер нь бодлогын голдуу бичиг баримтуудтай яваад байх болчихоод байна. Тийм учраас аль түвшиндээ бодлогын бичиг баримттай, аль түвшиндээ ажлын баримт бичиг нь давамгайлж явах юм гэдэг юмыг бид онцгой анхаармаар санагдаад байдаг. Сумын түвшин бол яг сумын өөрийнх нь, нэгжийнх нь чиг үүрэгт орчихсон асуудлаар л бодлогын баримт бичиг гаргана уу гэхээс бусад нь бол дээдэх бодлогуудыг хэрэгжүүлэх орон нутгийн онцлогтой ажлын баримт бичиг төлөвлөгөөнүүд л голдуу гарч явах ёстой л гэж ойлгоод байгаа юм. Үүн дээр ер нь ямар зохицуулалт, юу бодож оров гэдэг асуудлыг асууж байна аа.

**Г.Занданшатар:** 85. Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын хэлтсийн дарга Зохихсүрэн. Пүрэвийн Зохихсүрэн. 85.

**П.Зохихсүрэн:** Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Зохихсүрэн. Батжаргал гишүүний асуултад хариулъя. Засгийн газраас өргөн мэдүүлж байгаа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Төсвийн тухай болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нийтдээ 53 хуулийн төслийг өргөн барьж байгаа. Тэгэхээр хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиас бусад хууль нь бол 2020 оны 5 сарын 7-нд батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийнхөө тухай хуульд нийцүүлэх зорилгоор боловсруулж хуулийн давхардал хийдэл, зөрчлийг арилгах зорилготойгоор боловсруулсан ийм хуулийн төсөл байгаа.

Тэгээд таны хэлдгээр Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль маань хэрэгжиж эхлээд 1 жил боллоо. Энэ хугацаанд бол Улсын хөгжлийн бодлого нь бол суурь бодлого байх. Орон нутгийн түвшний бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь бол төлөвлөлтийн баримт бичиг байх хуулийн зохицуулалттай.

Хөгжлийн бодлогын тухай хуульд зааснаар бол урт хугацааны буюу 30 жилийн дунд хугацааны буюу 10 жилийн баримт бичиг нь бол бодлогын баримт бичиг. 5 ба 4, 1 гэсэн богино хугацааны бодлого төлөвлөлтийн баримт бичиг нь бол төлөвлөлтийн төрөлдөө орж хуульчлагдсан байгаа.

Тэгэхээр орон нутгийн түвшинд бол бодлогын баримт бичиг гэж байхгүй. Төлөвлөлтийн төрлийн баримт бичгүүд буюу Улсын хөгжлийн бодлого, мөн орон нутгийн онцлогт үндэслэсэн төлөвлөлтийн ийм баримт бичгүүд гарахаар бол хуульчлагдсан. Нөгөө талаар шинэчлэгдсэн энэ найруулга батлагдахаас өмнө

батлагдан хэрэгжиж байсан Үндэсний хөтөлбөр, төлөвлөгөө гэсэн салангид 567 бодлогын баримт бичиг байсныг хуульд нийцүүлэх арга хэмжээ авч байгаа. Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсан бодлогын баримт бичгийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн өргөн мэдүүлэхэд бэлэн болсон. Засгийн газрын тогтоолоор батлагдсаныг нь хүчингүй болгохоор тогтоолын төсөл сайд нараас санал аваад явж байна.

Орон нутгийн түвшинд батлагдсан энэ дэд хөтөлбөрүүд мөн орон нутгийн шинж чанартай төлөвлөлтийн.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Содномын Чинзориг цахимаар асуулт асууна.

**С.Чинзориг:** Гишүүддээ өглөөний мэнд хүргэе. Тэгэхээр энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь би бол дэмжиж байгаа юм. 2 хуулийн төслийг хамтатгаад хэлэлцэх нь зүйтэй байх гэж. Гэхдээ Засгийн газраас оруулж ирэхдээ хэд, хэдэн зүйлийг дутуу бодсон юм болов уу гэж л бодоод байгаа юм.

Нэг дэх асуудал нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульд чинь 5 жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг л үндэслэл болгоно гээд орчихсон. Тэгэхээр бидний баталсан дунд хугацааны болоод хэтийн төлөвлөгөө 2050 чинь үндсэндээ бол үндэслэл болохгүй юм шиг болчихоод байгаа юм. Энэ чинь бол Үндсэн хуулийнхаа заалттай зөрчилдөх гээд байгаа асуудлууд бол байгаа юм.

Хоёр дахь асуудал нь бусад хууль тогтоомжтой уялдуулах шаардлагатай байгаа. Ялангуяа бид нар сая жилийн төлөвлөгөө батлахад гарсан төсвийн хүрээний мэдэгдлийн хугацаа 5 сарын 1. Энэ жилийн төлөвлөгөө баталдаг хугацаа чинь 7 сарын 1 гээд.

Ингээд хууль хугацаа нь зөрчигдөж байгаа учраас бол асуудлууд үүсээд байгаа. Энэ асуудал бас зохицуулахаар орж ирээгүй байна лээ.

Гурав дахь асуудал нь Төрийн захиргааны төв байгууллагатай байна гэдгийг уг нь хуульчлаад оруулчихмаар байна. Энэ асуудал орж ирээгүй агентлаг хэвээрээ байгаа юм.

Дөрөв дэх асуудал нь хэрвээ хөгжлийн бодлого төлөвлөлтийн төрийн захиргааны төв байгууллагатай болох юм бол бусад Засгийн газрын тухай хуулиудад өөрчлөлт оруулах асуудал үүсэх болов уу гэж би бодоод байгаа юм. Одоогийн хуулиар чинь бүх яамнууд чинь бодлогын яам гэсэн статустай явж байгаа шүү дээ. Тэгэхээр Засгийн газрын тухай хуульдаа өөрчлөлт оруулах асуудлыг давхар авч үзэхгүй бол болохгүй байх. Би нэг минутаа нэмээд авчихъя дарга аа. Ер нь бол өмнөх төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед бол улсын хөгжил, төлөвлөлтийн асуудалд онцгой анхаарч байсан. Улсын төлөвлөгөөний комисс гэж байгууллага байсан. Би бас тэр Улсын төлөвлөгөөний комиссын бүтээгдэхүүний үлдэгдэл л дээ. Бас ямар нөхцөлд яаж ажиллаж байсныг бас гадарлана. Улсын төлөвлөгөөний комиссын дарга нь сайд нарын зөвлөлийн орлогч дарга, Улсын төлөвлөгөөний комиссын орлогч дарга нь Төрийн сайд гэсэн статустай явж бусад яамдаас нэлээн дээгүүр статустай явдаг байсан ийм асуудлууд бол бий шүү дээ. Ийм зүйлийг цаашдаа хэлэлцүүлгийн явцад анхаарах байх гэж.

Өчигдөр тэр буруу зарчим явсан даа дарга аа. Цаашдаа яах ёстой юм. Тэр Шүүхийн тамгын газар, Цэцийн Тамгын газрын дарга нарыг төрийн өндөр албан тушаалтантай адилтгадаг. Энэ бол захиргааны ажил хийдэг улсуудыг адилтгаад явчихсан буруу жишиг тогтсон шүү. Цаашдаа бас анхаарах ёстой байх. Хэрвээ энэ Үндсэн хуулийн байгууллагуудыг Тамгын даргыг нь төрийн өндөр албан тушаалтантай адилтгаж авч үзэж байгаа бол бусад Үндсэн хуулийн байгууллагуудад бас тэгш ижил хандах ёстой. Прокурорын байгууллага нь үлдэж байна лээ. Цаашдаа Прокурорын байгууллагын Тамгын даргыг нь адилтгаж, төрийн өндөр албан тушаалтны зэрэглэл ангилалд оруулах асуудлыг Их Хурлын дарга, Хууль зүйн байнгын хороо цаашдаа анхаарна биз дээ.

Ер нь бол бид нар Үндсэн хуулийн байгууллагууддаа ижил тэгш хандах ёстой гэсэн зарчмыг хаа хаанаа хатуу барьж баймаар байгаа юм.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Содномын Чинзоригт мэнчилгээ дэвшүүлнэ. Энэ 7 хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүддээ төрсөн өдрийн мэндчилгээ дэвшүүлье. 7 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хурлын эрхэм гишүүн Содномын Чинзориг эхээс мэндэлжээ. Төрсөн өдрийг тохиолдуулан эрхэм гишүүн Содномын Чинзориг доо эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Гэр бүлд нь бас сайн сайхныг хүсэн ерөөе. Содномын Чинзориг гишүүндээ төрсөн өдрийн мэнд хүргэе.

Содномын Чинзориг гишүүн 1 минут тодруулж асууна. Эрхэм гишүүн Ням-Осорын Учрал асуулт асууна. Ццрал гишүүн цахимаас танхим руу ороод ирсэн юм байна. Одоо эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт.

**С.Бямбацогт:** Сая Нямдорж сайд бас танилцуулгадаа хэллээ. Энэ Үндсэн хуульд 1 шинэ заалт ороод ирсэн, тэгээд шинэ хуультай болчихсон, би сайн ойлгохгүй байгаа гэж байгаа юм. Яг үүнтэй адилхан Засгийн газрын гишүүд, Үндэсний хөгжлийн газрынхан хөгжлийн бодлого, төлөвлөлт гэж юу юм бол. Ойлгодог юм болов уу, ойлгодоггүй юм болов уу, энийг хариулж өгөөч. Энэ хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу энэ хууль. Бараг дургүйд хүчгүй гэдэг шиг байгаад байх шиг байгаа юм.

Улсын Их Хурлаас Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль батлаад 2020 оны 5 сарын 7-нд 45 дугаар тогтоол хэрэгжүүл тогтоол баталж өгсөн. Хэрэгждэггүй. Тэгэнгүүт нь 2021 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр дахиад тогтоол баталж өгсөн. Энэ хуулийг хэрэгжүүл гээд.

Би Үндэсний хөгжлийн газрын дарга Батжаргал, дэд дарга Дөлгөөн 2-оос яг тодорхой асуучихъя. Энэ 10 дугаар тогтоолын 2 дахь заалт, 4 дэх заалт хэрэгжиж байгаа юу. Энийг та 2 хариулж өгнө. 2 дахь заалт. 4 дэх заалт. Би хэлэхгүй.

Сангийн яамнаас хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бодлогын бичиг баримтууд. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд төсөв байх ёстой юм уу. Эсвэл төсөв маань дарга дагасан хэн нэгэн эрх мэдэлтэнд тал зассан бодлогогүй төсөв байх ёстой юм уу? Өөрөөр хэлэх юм бол Монгол Улсыг хөгжүүлэх хөгжлийн төсөв байх ёстой юу, үгүй юу? Төсвийн тухай хуулийг хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд нийцүүл гээд бид үүрэг өгөөд байдаг. Нийцүүлж оруулж ирж байгаа юу, үгүй юу. Төсвийн хууль нь том юм уу, эсвэл хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль нь том юм уу.



Тэгээд л зөрчилтэй хууль, зөрчилтэй хуулийнхаа зөрчлийг арилгадаггүй төв нь садаа болдог. Энэ асуудлыг Сангийн яамнаас асуучихъя бас.

Дараагийн асуулт. Энэ хуулийг сурталчлах, таниулах талаар ажлууд яаж хийж, хэрэгжүүлэх вэ? 1990 оноос.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт гүйцээж асууна.

**С.Бямбацогт:** 1990 оноос өмнө Улсын төлөвлөгөөний комисс гэж байсан. Үнэхээр ажил хийдэг, хэрэгжүүлдэг бүх бодлогыг зангиддаг. Монгол Улсыг хөгжүүлэхэд эрчимтэй ажлууд хийгддэг байсан. 1990 оноос хойш үндсэндээ 30 жил хөгжлийн бодлого, хөгжлийн загвар, хөгжлийн төлөвлөлт гэдэг үгнүүдийг мартчихсан 30 жилийн дараа шинээр гараад ирэхээр энэ төлөвлөлт гэж юу юм бол, бодлого гэж юу юм бол, хөгжлийн загвар гэж юу юм бол гэдэг юм ерөөсөө ойлгодоггүй. Ийм л байдалтай байгаад байна л даа. Тэгээд үүнийгээ яаж ойлгуулдаг болох вэ? Энэ тал дээр Засгийн газар, Хэрэг Эрхлэх газар ямар арга хэмжээ цааш нь авч хэрэгжүүлэх гэж байна вэ? Энэ талд үнэхээр дутагдалтай байгаад байгаа. Сайд нар ч хэлээд байгаа, Засаг дарга ч хэлээд байгаа. Ерөөсөө ойлголт байхгүй. Ерөөсөө шинэ үг гэнэтхэн л тэнгэрээс буугаад ирчихсэн шинэ үг л юм шиг тийм ойлголттой. Энэ тал дээр ер нь тэгээд ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ цаашдаа.

**Г.Занданшатар:** 81. Цэндийн Нямдорж сайд.Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга.

**Ц.Нямдорж:** Засгийн газар хууль биелүүлдэг л байгууллага. Тийм учраас батлагдаад мөрдөгдөж байгаа хуулийг хэрэгтэй, хэрэггүй гэж аль нэг үг хэлэх эрх бидэнд байхгүй. Анхаарах асуудал бол байна байна. Гишүүд ч өөрсдөө ярьж байгаа. Засгийн газрын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл явж байгаа. Энэ хуулийн төсөл дотор эдийн засгийн асуудал хариуцсан яам шинээр байгуулах санал явж байгаа. Тооцоо нь бол намар өргөн мэдүүлээд, батлуулаад, ирэх оноос ажиллуулж, эхлүүлэх тооцоотой.

Тэгээд яам байгууллагдаад сайд нь ажлаа хариуцаад явах юм бол энэ гарсан хуулийг боловсронгуй болгох, гишүүдийн яриад байгаа асуудлыг цэгцлэх тал дээр үйл ажиллагаа явуулах байх гэж бодож байна.

Хоёрдугаарт. Энэ бол шинэ хууль. Нэг талаас, нөгөө талаас сүүлийн 30 жилийн Монголын амьдрал бол энэ улс 300 жилийн дараа бие дааж амьдрах гэсэн л тийм оролдлого. Улс төрийн хувьд, эдийн засгийн хувьд, нийгмийн харилцааны хувьд. 55 хуультай байсан улс одоо 800-аад хуулийн хүрээнд амьдралаа зохицуулж байна. Эхний 12 жил нь бол картаас эхлээд ямар ч хөгжил, хөрөнгө оруулалтын асуудал байхгүй 12 жил байсан. 2002 оноос хойш 20 шахам жилийн хугацаанд урагшаа жаахан алхаж байгаа. Юу болоод өнгөрснийг та бүхэн мэдэж байгаа. Цаашдаа шинэ хөгжлийн 30 жил эхэллээ гэдгийг зарласан. Энэ баримт бичгийнхээ хүрээнд, хөгжлийнхөө бодлого, төлөвлөлтийн асуудлыг цаашаа боловсронгуй болгоод явах байх. Шийдэгдсэн асуудлууд байна. Дандаа юмыг.../минут дуусав/

**Г.Занданшатар:** 81. Нямдорж сайд гүйцээж хариулъя.

**Ц.Нямдорж:** Шийдэгдсэн асуудлууд энэ 30 жилд байна. 30-аас энэ 12-ыг нь би хасаж ярьдаг юм байнга. Энэ улс чинь авто замгүй байсан. Сүлжээ байгаагүй. Одоо бүх аймгууд холбогдсон. 2007 онд Монголын 337 сумын 167 нь харанхуй байсан юм. Одоо эрчим хүчтэй ямартай ч байсан гэрэл гэгээтэй болсон. Том төслүүд хөдөлж эхэлж байна. Залгуулаад дараачийн төслүүдээ хөдөлгөөд, хөгжлийнхөө асуудлыг шийдээд явах юм бол энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн хуульд сууриалаад бусад хуульд сууриалаад урагшаа явах бололцоонууд байна.

1990-ээд оны Улсын төсвийн хэмжээ одоогийнх 2-ыг харьцуулаад үзэх юм бол харьцуулах аргагүй том болсон. Харьцуулах аргагүй том болсон. Хэд дахин нэмэгдсэн гэдгийг бас хэлье гэж бодсон юм. Бусад асуудлаар манай ажлын хэсгийн нөхдүүд хариулах байх. Ер нь ингэсэн шүү дээ.

**Г.Занданшатар:** 80. Ханджавын Батжаргал. Тэр хуулийн 2 заалтын хэрэгжилт ямар байна гэсэн.

**Х.Батжаргал:** Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын 2021 оны 10 дугаар тогтоолоор 5 зүйл, заалт бүхий чиглэл өгөгдсөн байж байгаа.

Хоёрдугаар зүйлд бол Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тайлагнах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх талаар салбар, орон нутгийн нэгдсэн удирдлага, арга зүй болон шаардлагатай системчлэл, загварчлал гарын авлага, программаар хангах ажлыг зохион байгуулах гэсэн байгаа. Арга зүйн хувьд Монгол Улсын Засгийн газраас 119 дүгээр тогтоол гарч батлагдаж, түүний холбогдох хөгжлийн бодлого, баримт бичгийг боловсруулах журам батлагдсан байгаа.

Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын даргын тушаалаар тэр журмын дагуу төлөвлөх аргачлалыг боловсруулж бас батлуулан орон нутагт цахимаар болон шат дараатайгаар энэ аргачлалыг таниулан мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна аа.

Дөрөвдүгээр зүйл буюу хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд төсвийн болон холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын хүрээнд боловсруулсан хуулийн төслүүдийг 2021 оны хаврын чуулганы хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гэсэн байгаа. Тэгээд түүний дагуу өнөөдөр судалгаа, шинжилгээ хийгээд 53 хуулийн тодорхой зүйл заалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар Засгийн газраас өргөн мэдүүлээд хэлэлцэж байна.

**Г.Занданшатар:** Хоёрт хуулийн хэрэгжилтийн хөгжлийн бодлого гэж юу юм, хөгжлийн төлөвлөлт гэж юу юм бэ гээд байгаа шүү дээ, ойлгож байна уу гэсэн энэ Батжаргал дарга, Ханджавын Батжаргал. 80 дээр.

**Х.Батжаргал:** Монгол улс хөгжлийн загварчлалын хувьд хөгжлийн бодлого төлөвлөлтөд суурилсан.

**Г.Занданшатар:** Үгүй ээ. Хөгжлийн бодлого төлөвлөлт гэж юу юм бэ. Яг тэрний нь хэлчих. Тэрийг ойлгож байгаа юу гэсэн.

**Х.Батжаргал:** Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого буюу 2050-д тодорхой зүйл, заалт, бүлгээр заасан урт хугацааны хөгжлийн бодлогыг чиг баримжаагаа болгоод, дунд хугацаандаа 10 жилээр хэрэгжүүлээд явж байгаа. Төлөвлөлтийн хувьд хөгжлийн бодлогыг даган гарсан хэрэгжүүлэх үйл

ажиллагаагаа төлөвлөж байгаа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөлт болон хөгжлийн жилийн төлөвлөгөөг бас хуульд заасны дагуу бол төлөвлөлт хийгээд явагдах заалттай байгаа. Түүнийг хэрэгжүүлээд явж байгаа.

**Г.Занданшатар:** Үндэсний хөгжлийн газрын дарга Хөгжлийн бодлого гэж “Улс салбар, салбар хооронд болон улс орон нутгийн түвшинд урт, дунд, богино хугацааны хөгжлийн тодорхой асуудлаар ахиц дэвшилд хүргэхээр дэвшүүлсэн хэмжигдэхүйц зорилго зорилт, тэдгээрийн суурь түвшин, хүрэх үр дүн, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, санхүүжилтийн эх үүсвэрээ баталгаажсан төсөв, хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг тусгасан эрх зүйн баримт бичгийг хөгжлийн бодлого гэнэ” гээд хуульд заачихсан.

Хөгжлийн төлөвлөлт гэдгийг жилийн төлөвлөгөө оруулж ирэхдээ та нар ойлгоогүй гэж энийг тодруулж асуугаад байгаа юм.

Хөгжлийн бодлогын хэмжигдэхүйц зорилго, зорилтуудыг үе шаттайгаар тодорхой хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааг хэлнэ гэж байгаа шүү дээ. Тэгээд үйл ажиллагаа оруулж ирээгүй, жилийн төлөвлөгөө оруулж ирэхдээ. Жилд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын хөгжлийн төлөвлөлтийн баримт чинь хөгжлийн төлөвлөлт байхгүй юу. Энийгээ л яс цээжилчихсэн баймаар байгаа юм ядаж. За 88. Галсандоржийн Батхүрэл.

**Г.Батхүрэл:** Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга Батхүрэл. Тэгэхээр хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль бол 2020 оны 5 сарын 7-ны өдөр Улсын Их Хурлаар батлагдсан. Энэ хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд Улсын Их Хурлаас 45 дугаар тогтоол гарсан байгаа. Энэ тогтоолын гол 4 дүгээр заалт бол Төсвийн тухай болон холбогдох бусад хуульд нийцүүлж, төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тухай заалт өгсөн байдаг. Энэ дагуу Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан тушаал гарсан байгаа.

Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулийг энэ хуульд нийцүүлэн боловсруулаарай гэдэг ийм үүрэг өгсөн. Тэгээд энэ дагуу хамтарсан 2 даргын тушаал гарсан. Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дэд даргаар ахлуулсан Сангийн яамнаас оролцсон Хууль зүйн яамнаас, Үндэсний хөгжлийн газраас холбогдох дарга нар орж ажилласан. Ийм ажлын хэсэг гарсан. Энэ ажлын хэсгийн хүрээнд бол Төсвийн хуульд бол дараах холбогдох хуулийн өөрчлөлтүүд орсон.

Хуулийн гол 9.1 дээр Улсын Их Хурал төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэсэн ийм заалт байдаг. За энэ заалтын 9.1.2-т бол дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлээд, улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөв, нийгмийн даатгалын сангийн төсөв, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв тэдгээрийн тодотголыг хэлэлцэн батлах гэсэн ийм заалт байсан. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл маань 5 жилийн бодлогын баримт бичиг болж өөрчлөгдсөн учраас үүний оронд бол улсын хөгжлийн төлөвлөгөө гэдэг ийм шинэ хуулийн зохицуулалтыг нийцүүлж оруулсан байгаа. За дээрээс нь 10.1 дээр бол Засгийн газрын.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Сандагийн Бямбацогт гишүүн тодруулж асууя.

**С.Бямбацогт:** Батхүрэл дарга аа, Төсвийн тухай болон холбогдох бусад хуулийг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульд нийцүүлж 2020 оны 10 сарын 1-ний дотор өргөн мэдүүл гэж 45 дугаар тогтоолд заасан.

Энэ хэрэгжихгүй болохоор нь 2021 оны 1 дүгээр сарын 21-нд хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд Төсвийн болон холбогдох бусад хууль тогтоомжийг нийцүүл гээд заачихсан юм. Та тэгэхээр төсвийн хуульд нийцүүлж хөгжлийн бодлого болон бусад хуулийг өөрчил гэсэн гэж яриад байх юм.

Тэгээд хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд Улсын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Улсын төсөвт чиглэгдэнэ гээд хуульд заачихсан байгаа. Би буруу яриад байна уу? Эсвэл та буруу яриад байна уу? 2-уулаа ойлголтын зөрүүгээ алга болгочихъё. Олон нийт ч гэсэн ойлголтын зөрүүг алга болгох ёстой байх. Энэ дээр та дахиад нэг тодруулаад хариулт өгчих. Яг хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хуульд юу гэж заасан байгаа. Улсын Их Хурлын тогтоолд юу гэж заасан байгааг.

**Г.Занданшатар:** 88. Галсандоржийн Батхүрэл.

**Г.Батхүрэл:** Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын 45 дугаар тогтоолоор. Сая би жаахан андуураад хэлсэн байна. Уучлал хүсэж байна. Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хуулийг энэ хууль гэдэг маань Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиа хэлээд байгаа юм. Энэ хуульд нийцүүлж, боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлээрэй гэсэн ийм заалт байгаа. Үүний дагуу холбогдох өөрчлөлтийг Төсвийн тухай хууль дээр оруулсан.

Миний түрүүчийн хэлсэн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн өөрчлөлтийг 9.1.2 дээр оруулсан байгаа. Үүний дараа бол Засгийн газрын төсвийн талаарх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гээд. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг бол Засгийн газраар батлах ийм зохицуулалт байсан. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр маань Монгол Улсын Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хавсралт болоод Улсын Их Хурлын тогтоолоор батлах хуулийн зохицуулалт бий болсон учраас энэ хуульд нийцүүлж, төсвийн тухай хуульдаа холбогдох өөрчлөлтийг нь оруулсан байгаа.

**Г.Занданшатар:** Одоо эрхэм гишүүн Ням-Осорын Учрал.

**Н.Учрал:** Энэ тандалт судалгаан дээр байна. Швейцар энэ английн жишээ, хятадын жишээ. Тэгээд энэ гаднын улсуудыг харахад бол угаасаа тогтвортой хөгжлийн зорилтын 80 гаруй хувь нь мэдээллийн технологиос хамааралтай. Хөгжлийн хурдасгуур нь өөрөө харилцаа холбооны салбар юм гэдгийг тодотгоод өгчихсөн байдаг. Тэгэхээр Засгийн газар хуульдаа нийцүүлээд төлөвлөгөөгөө танилцуулахдаа бол харилцаа холбоог өөрөө хөгжлийн хурдасгуур гэж авч үзэж, тэр мэдээллийн технологийн дэвшлийг хэрэглэж байгаа байдал бол ерөөсөө харагдахгүй байгаа шүү дээ. Нэг ёсондоо бол өмнө нь гаргасан төлөвлөгөө дээрээ хэдэн үг, үсэг нэмээд л нэг төлөвлөгөө батлуулдаг байдалтай л яваад байгаа юм. Тэгээд би ойлгож байна л даа. Өнгөрсөн хугацаанд бас харж үзсэн, мэдэрсэн зүйл бол. Ер нь өөрөө манай төрийн байгууллагууд, улс төрчид бол Үндэсний хөгжлийн газрыг, Оюуны өмчийн газрыг, Статистикийн хороо гээд газрыг үнэндээ тоодоггүй юм байна лээ. Харин Хөгжлийн газар чинь өмнө нь концессын газар гээд нэртэй ч байл уу, хөрөнгө оруулалтын газар гээд нэртэй байхад бол аягүй тоодог байсан.

Өнөөдөр бол Хөгжлийн газар гээд та нар ийм бичиг цаас гаргаад, өнөөдөр ийм байна, цаашдаа ийм болох ёстой гэж ярихад бол нэг их анхаарахгүй байх.

Тэгэхээр би Үндэсний хөгжлийн газрынхнаас нэг зүйлийг асуух гээд байгаа юм. Та нар ер нь ажил явуулах боломж хэр байдаг юм бэ. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийг энэ хуулийн дагуу оруулж ирэхэд та нарт хүний нөөцийн чадамж байна уу? Дээрээс нь та нарын хэлсэн үгийг ер нь энэ Засгийн газар, сайдууд сонсдог юм уу? Засгийн газрын гишүүд чинь бол үе үед л угаасаа л аж ахуй л ярьдаг юм байна лээ шүү дээ. Аж ахуйгаа яриад байна уу. Эсвэл та нарын энэ хөгжлийн бодлогыг ер нь сонсдог юм уу? Тэгээд эргээд эцэстээ Их Хурал дээр та нар асуугдаад байдаг, ажил явуулах боломж үнэндээ байдаггүй л гэдэг тайлбарыг өөрсдөө өгдөг шүү дээ. Ажил явуулах боломж байна уу цаашдаа.

**Г.Занданшатар:** Цэндийн Нямдорж. 81. Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын дарга хариулна.

**Ц.Нямдорж:** Яг тулсан асуултад энэ зовлонгоо Батжаргал дарга ярих юм байгаа биз дээ. Гишүүд ер нь ийм шүү дээ. Энэ төлөвлөгөөний комисс гэж байж байгаад татан буугдчихсан. Тэгээд 2008 оны үед шиг санагдаж байна. Үндэсний хөгжлийн газрыг анх байгуулсан. Хашчулуун гэдэг даргатай байсан. Нэг их олигтой юм болоогүй үнэнийг хэлэхэд. 2012 оны сонгуулийн өмнөхөн хууль батлагдаад Эдийн засгийн хөгжлийн яам гэж яам байгуулахаар шийдвэрлэсэн. 2012-2014 оны хооронд энэ яам үйл ажиллагаа явуулаад татан буугдсан. Тэрний дараа Үндэсний хөгжлийн газар гэж дахиад гарч ирээд Баярсайхан, Батжаргал гэдэг 2 даргатайгаар л өнөөдөр хүрч байна л даа. Түүх нь ийм юм.

Өөрөөр хэлбэл энэ асуудал хариуцсан байгууллага үйл ажиллагааны хувьд ч тэр, боловсон хүчний хувьд ч шаардлагын хэмжээнд хүрч чадаагүй байгаа. Энэ шинэ яам байгуулаад, тэр яамыг нь холбогдох сайд нь толгойлсон тохиолдолд энэ хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль хэрэгжээд эхлэх юм бол өөрчлөлт гарна гэсэн ийм байдалтай байгаа шүү дээ. Тоох, тоохгүйн тухайд бол хэрэг эрхлэх газраар дамжуулаад яамдтайгаа л Батжаргал дарга харилцаж байгаа л даа. Одоохондоо бол сайд нар нь их зан гаргасан, үл тоосон тийм юм ажиглагдахгүй байна. Мэдээж хэрэг сайд бол сайд, агентлагийн дарга бол агентлагийн дарга л байдаг. Тэрний хооронд гардаг үл ойлголцлыг хэрэг эрхлэхээрээ дамжуулаад зохицуулах ийм л ажлууд хийгдэж байгаа гэдгийг би хэлье. Боловсон хүчний хувьд бол эд нар чинь цөөхөн хүнтэй шүү дээ. Өнгөрсөн жил 11 сард шийдвэр гараад энэ байгууллагыг 2 хуваагаад тэр худалдан авах ажиллагааны газарт цөөхөн хүнтэй газарт ... минут дуусав/

**Г.Занданшатар:** Одоо эрхэм гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг.

**М.Оюунчимэг:** Яг миний хөндөх гэж байгаа асуудлыг сая Нямдорж сайд дутуу яг ярьчихлаа л даа. Би энэ дээр боловсон хүчин, хүний нөөцийн асуудал үнэхээр чухал байна. Бид нар энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай маш чухал баримт бичгийг өнөөдөр гаргах гээд сууж байна. Бид нар төрийн албаны зөвлөл дээр уржигдар ажиллалаа. Өнөөдөр яам, агентлагууд зүгээр л хүний нөөцгүй болчихсон хүмүүсээ бараг тэнд ажиллаж байгаа хүмүүсийг 2, 3 хувааж болохоор байна гэж байгаа юм. Нэг нь даргын үүд дагаж нэг цаас барьж намирсан хэсэгхэн хүн, нэг хэсэг нь ажиллаж байгаа, ажиллахгүй байгаа нь мэдэгдэхгүй нэг хэсэг хүн, цөөн хэсэгт нь хамаг ачаалал нь ноогддог. Тэгээд хамгийн гол нь бид төрийн албаны хуулиар тогтвортой байх, хариуцлагатай байх, ёс зүйтэй байх, ур

чадвартай байх гээд оролдсон чинь тогтвортой гэдгээр мерит зарчмаар олон жил ажилласан ч гэдэг юм уу, эсвэл удаан хугацаанд тэднийхийг нэлээд дархлааг нь тогтоогоод өгчихсөн учраас хэдэн сараар амралт, чөлөө аваад явчхаад гээд. Одоо төрийн энэ алба маань боловсон хүчний нөөцгүй болчихоод байна чадамжтай. Өнөөдөр яам, тамгын газруудаас Улсын Их Хурал дээр орж ирж байгаа баримт бичгүүдийг яаж байна. Бараг үндсээр нь өөрчилж 137, 140-өөр санал хураалт явагдаж байна шүү дээ. Иймэрхүү байдлаас болоод энэ хүний нөөц маш чухал байна.

Өнөөдөр бид нарын энд яриад байгаа энэ баримт бичгийг хөгжлийн бодлого, төлөвлөлт, уялдаа холбоог энийг хийх хүн, хүн өөрөө энийг хүнгүйгээр хийхгүй. Одоогоор бид нар автоматжаагүй байна. Энийг робот ирээд хийчихгүй. Тэгэхээр энийг хэрэгжүүлэх үүднээс өнөөдөр хүний нөөцөө бэлдмээр байна. Өнөөдөр яам, тамгын газрууд нь хүнээ мэргэшүүлдэг шүү дээ. Жишээ нь. Би лав телевизэд ажилладаг байхдаа байсхийж байгаад л яг өөрөө тэр юмаа бөглөөд л Америк, Япон, Голланд гэдэг юм уу эсвэл Монголдоо банк санхүүгийн чиглэлээр ч гэдэг юм уу ингээд сураад л, мэргэшил дээшлүүлээд л яваад байдаг. Одоо энэ бүр бүх газар зогсчихоод байна. Тэгэхээр энэ хугацаанд энэ хүний нөөцөө бэлдэх, мэргэшил дээшлүүлэх, сургах энэ асуудал бол бүр нэн чухал байна. Тэгэхээр энэ дээр яаж бэлдэж байна вэ? Энийг яаж хангах вэ?

Өнөөдөр орчны бохирдлыг бууруулах гэхэд өнөөдөр хүнгүй болсон байгаад байна. Жишээлбэл Байгаль орчны яам ч.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн нэмэлт нэг минутаа тодруулъя. Дараа нь санал хураалттай гишүүд бэлдэж байгаарай.

**М.Оюунчимэг:** Миний өнөөдөр ингэж саналаа ингэж анхааруулж хэлээд байгаа зүйл нь юу юм бэ гэхээр сая Бямбацогт дарга ч хэлээд байна л даа. Тэр нэг уялдаа холбоогүй бүх газар юм нь тодорхойгүй. Хэн, юу хийх нь гээд. Одоо ганцхан жишээ хэлье. Байгаль орчны яаманд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо гээд хуучин нийслэлд байсан. Одоо Байгаль орчны яаман дээр ирсэн гээд байгаа юм. Тэгсэн хэр нь энэ ажил нь зогссон. Юу хийж байна вэ гэхээр ганцхан Туул гол хавьд нэг юу барих асуудал жорлон барих асуудал гээд аж ахуйн юм руу хөөцөлдөөд явсан. Гэтэл бид ирэх жилүүдэд утаагаа дахиад нэг 80 хувь хүртэл бууруулна гэсэн. Аймгийн төвүүд утаатай болсон гэхэд энэ жишээ нь хаана очих юм бэ гэдэг нь тодорхойгүй.

Нийслэлд нэг бүтэц бас байгаад байгаа юм. Тэгсэн хөрөнгө нь Байгаль орчны яам дээр ирсэн бидэнд мөнгө төгрөг байхгүй гээд байгаа юм. Туул гол хамгаалах гээд л хотын дарга ч хамгаалах гээд байгаа юм шиг, Байгаль орчны яам ч хамгаалах гээд байгаа юм шиг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт гээд бид энд ярьдаг. Гэтэл төсөв нь Сангийн яам дээр ирээд танагддаг ч гэдэг юм уу. Тэгээд яг энэ уялдаа холбоо хүний нөөц хоёр өнөөдөр байхгүй байна. Энийг хийхгүйгээр бид нарын энэ баримт бичиг хэрэгжихгүй.

**Г.Занданшатар:** 81 Цэндийн Нямдорж сайд асуултад хариулна.

**Ц.Нямдорж:** Зарим шүүмжлэл үндэстэй гэдгийг ер нь одоо энэ манай энэ боловсон хүчний чадавх бол төвөгтэй л байгаа шүү дээ. Хоёр үндсэн шалтгаан байгаа. 1 дүгээрт энэ үе шилжилт гэдэг юм маань яам, төрийн захиргааны төрийн бүх байгууллагуудад аймшигтай хурдан явагдаж байгаа Монголд. Би 89 онд

прокуророос гараад 2000 онд очиход Улсын прокурор, хотын прокурор, дүүргийн прокурорын түвшинд миний таньдаг 10-аадхан хүн үлдсэн байсан. 2012 онд би ажлаа өгч яваад 5 жилийн дараа буцаж очиход манай яамны 74 ажилтнаас 20 нь үлдсэн байсан миний таньдаг.

Бусад нь бүгд шинэчлэгдсэн. Ийм шилжилтүүд аймшигтай явагдаад байгаа байхгүй юу. Энэ нь эргээд ажлынхаа чадавх чансаа мэргэших гэх мэтийн энэ асуудалд. 3 дугаар шалтгаан нь энэ сонгууль дагасан боловсон хүчний хөдөлгөөн. Аймгийн дарга солигдоод намын харьяалал нь солигдохоор бөөнөөр нь халдаг сольдог. Эрх барьж байгаа нам нь өөрчлөгдөөд сайд нь шинэ сайдаар томилогдохоор дагаад баахан өөрчлөлтүүд хийдэг. Ингээд тогтож байгаа боловсон хүчнээ улс төрийн зорилгоор хөдөлгөөд байдаг явдал чинь энэ ажилд их муугаар нөлөөлөөд байна шүү дээ.

Энэ 16 оны Их Хурлын баталсан Төрийн албаны хууль бол тэр мерит зарчим баримталсан уг нь гайгүй хууль л даа. Одоо ингээд эргээд харж байхад бол дахиад л тэр хууль байгаа боловч Засаг дарга нь өөрчлөгдсөн аймгуудад 40-өөд хувь нь өөрчлөгдөж байна шүү дээ. Говь-Алтай, Архангай. Сайд нь өөрчлөгдсөн зарим юунд яамдад 40-өөд хувийн түр хүмүүс ажиллаад энийгээ зас гэдэг шаардлага тавиад явж байна л даа. Ийм, ийм шалтгаанууд байгаа юм. Тэгээд мэдээж хэрэг ажил хариуцаж байгаа хүмүүсийн чадавх.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гүйцээгээд хариулъя. 81 Цэндийн Нямдорж сайд гүйцээж хариулъя.

**Ц.Нямдорж:** Ийм асуудлууд байгаа. Давхардал хийдэл ч гэсэн байгаа л даа. Энэ утаатай дүүрэг нь тэмцээд байдаг. Хот нь тэмцээд байдаг. Байгалийн яам нь тэмцээд байдаг. Уялдааны асуудал гээд ингээд давхардал хийдлийг харах асуудал зөндөө байгаа. Цаашдаа энэ дээр анхаарч ажиллана. Сангийн яамтай холбогдолтой асуудал. Одоо бид нарын зовлон. Яг Үндсэн чанараараа бол салбар ажлаа хийе гэх юм бол хэрэгцээ мөнгөний хэрэгцээ бол 100 их наяд төгрөг. Бид нарын эргэлдэж байгаа мөнгө бол 12-15 их наяд төгрөг л байгаа.

Сангийнхаас бусад бүх сайд нар үеийн үед Бямбацогт гишүүн сайд байсан. Сангийн яамнаасаа мөнгө нэхдэг. Асуудлаа шийдэх гээд, Сангийн яам нь миний халаасанд байгаа мөнгөний хэмжээ 12 их наяд төгрөг байна гээд суучихдаг. Эндээ баригдахаас өөр ямар ч гарцгүйгээр бид нар явж байгаа шүү дээ. Хүссэн ч, эс хүссэн ч энэ Монголын зовлон энэ. Дээрээс нь.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Алга байна. Цахимаар 1 хүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Сандагийн Бямбацогт үг хэлнэ. Дараа нь Цэрэнпилийн Даваасүрэн гишүүнээр тасаллаа. Дараа нь санал хураалттай.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Засгийн газрын өргөн барьсан хуулийг дэмжиж байгаа. Үндсэн хуульд хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна. Монгол Улсын энэ хөгжлийн бодлогод нийцүүлж Засгийн газрын мөрийн хөтөлбөр, жилийн төлөвлөгөө, үндсэн чиглэл бүх юм улсын төсөв нийцэж байх ёстой гээд Үндсэн хуульдаа оруулсан. Энэ үндсэндээ бол аргагүй нэг шинэ болчхоод байгаа юм. 30 жил бид нар төлөвлөлтгүй бодлогогүй, төрийн бодлого нь тодорхой биш, төрийн бодлого нь тогтворгүй явж ирсэн.

Одоо бас нэг бодлого нь тогтвортой, бодлого нь тодорхой, улс орноо хөгжүүлэхийн төлөө бас алсыг харсан. 1000 бээрийн аялал нэг алхмаас эхэлдэг гэж ярьдаг шүү дээ. 1000 бээрийн цаана хүрэх гэж байгаа бол нэг алхаж байж л хүрнэ. Алхам алхмаар хүрнэ. Ийм байдлаар л бас нэг улс орноо хөгжүүлэхийн тулд бас нэн төлөвлөж төлөвлөснөө хэрэгжүүлэхийн төлөө бас нэг баримжаатай явах хэрэгтэй байгаа юм. Сая одоо асууж байгаа асуулт нь манай Үндэсний хөгжлийн газар хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан агентлаг ганцхан агентлагтай. Удирдлагууд харьцангуй одоо сул хариулж байна. Хөгжлийн бодлого гэж юу билээ асуусан ойлголт муутай. Хөгжлийн төлөвлөлт юу билээ асуусан ойлголт муутай. Сангийн яамныхан бас. Ийм байдалтай ажиллахгүй.

Энэ ажлаа жаахан энэ зун юу гэдэг юм хариуцсан газар нь удирдлагууд нь өнөөдөр энэ асуудлыг хариуцсан хүмүүс нь өөрсдөө ийм ойлголт муутай байхад өнөөдөр тэр яамны сайд нар тэр аймаг, орон нутгийн Засаг дарга энийг чинь ойлгоно гэвэл бүр хэцүү. 5 жилийн төлөвлөгөө гэж юу юм бэ, 5 жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхийн өмнө 1 жилийн төлөвлөгөө яаж хийх ёстой юм. Оруулж ирсэн жилийн төлөвлөгөө чинь асуудалтай байсан. Нэг их сайн юм оруулаад ирсэн юм шиг тэгээд л Дөлгөөнөө. Зурагт дотор ороод л байнга суучихдаг. Сонин дээр байнга нэрээ бичүүлдэг. Эхлээд хуулиа унш.

Эхлээд энэ хөгжлийн бодлого гэдэг юмаа ойлго. Тэгээд дараа нь тийм үү тэр телевиз дотроо ор, тэр сонин дээр нэрээ бичүүл. Өөрсдөө энэ зун юмаа ойлго та нар. Тэгээд наадах ойлголтоо өөрсдийн ойлгосон мэдсэн сурсан юмнуудаа тэр Улсын Их Хурлын тогтоолын хоёрт заасан Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг тайлагнах, хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх талаар салбар болон орон нутгийн нэгдсэн удирдлага арга зүй болон шаардлагатай системчлэл, загварчлал, аргачлал, гарын авлага, программ хангах, хүний нөөцийг бэлтгэх, сургах энэ ажлыг хийж хэрэгжүүл, энэ зундаа хийж хэрэгжүүлээрэй. Ийм байдлаар ажиллахгүй. Ганцхан журам баталсан гээд сууж байдаг.

Энд чинь өчнөөн олон юм заасан байгаа. Өөрсдөө ойлголттой болчихоод бусад хүмүүстээ өөрсдийн ойлгосон мэдсэн сурснаа зааж өг. Ингэхгүй бол энэ чинь яах аргагүй шинэ бодлого, шинэ түвэг болчихоод байна. Та бүхэн өөрсдөө юмаа ойлгохгүй бол яаж бусад ойлгож энэ хуулийг хэрэгжүүлэх юм бэ? Засгийн газрын хуулийн хэрэгжилтийг хангах үүрэгтэй. Тийм болохоор энэ хуулийг хэрэгжүүлэх ажил тийм үү яг үндэсний хөгжлийг бас хариуцсан хүмүүс нь энэ ажлаа жаахан санаачилгатай, идэвхтэй, залуу хүмүүс байна шүү дээ. Өөрсдөө ажилламаар байна.

Тэгээд бусдадаа тийм үү, зааж сургах, энэ сургалтаа явуулах, боловсон хүчнээ бэлдэх, энэ аргачлал загварчлал, гарын авлага, системчлэл энэ юмаа хийх энэ ажлуудаа нэлээн сайн хиймээр байна. Ингэж байж явна. Тэгэхгүйгээр одоо юу гэдэг юм болохгүй байна, бүтэхгүй байна.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн. Дараа нь санал хураалт явна гишүүд бэлдээрэй.

**Ц.Даваасүрэн:** Би хуулийн төслийг дэмжиж үг хэлж байгаа юм. Гэхдээ бид нар бас энэ ер нь энэ төлөвлөлтийн асуудал энэ бодлогын хэрэгжихгүй байгаа асуудал дээр энэ анхаарах зүйл бол ер нь энэ нөгөө хуулийн хууль өөрчлөөд



байхдаа ч гэдэг юм уу энэ бүтцэдээ байгаад байгаа ч асуудал бас биш л дээ. Бид нар жишээлбэл Засгийн газрын үйл ажиллагаа муу болохоор нь Засгийн газрын гишүүнд Их Хурал хариуцлага тооцдог болгоод л Засгийн газарт өглөө. Тэгээд эрс өөрчлөгдөж байгаа юм бас нэг харагдахгүй л байна шүү дээ. Би зүгээр яг нэг жишээ хэлье. Одоо жишээлбэл өчигдрийн болсон асуудал тийм үү. Улс орон даяараа тог тасарлаа.

Энэ нэг усан цахилгаан станц, энэ 5 дугаар станц гэдэг юм уу аль эсхүл Багануурын станц гэдэг ч юм уу эрчим хүчний нэг дунд хугацааны төлбөр гээд бидний нэг хийгээд өгчхөөд энийг хийчих юм бол энэ эрчим хүчний ийм хүндрэлтэй нөхцөл байдал үүсэхгүй гээд ингээд байхад энд мөнгө гаргаж өгдөггүй л байхгүй юу. Тэгсэн мөртөө бол одоо ингээд л халамж сонгуулийн холбогдолтой зардалд бол асар их хэмжээний мөнгө. Сая сүүлийн 2 жил гарсан мөнгөөр бол бидэнд шаардлагатай станц бариад 3, 4 ийм станц барих мөнгийг бид нар зүгээр л цацаж байгаа байхгүй юу даа. Зүгээр л цацаж байгаа.

Тэгсэн мөртөө яг станцаа барья гэхээр мөнгөгүй гээд суугаад байгаа байхгүй юу. Энд л энэ бид нарын энэ сэтгэхүйд энэ нэг хүсэл эрмэлзэлгүй байгаа байдал энэ ёс суртахуунд л асуудал бол байгаа шүү дээ. Тэрнээс биш бол мөнгөндөө биш юм байна. Би бол хуульдаа биш юм байна гэж бодож байна. Би тэр Үндсэн хуульд байгаа гэсэн шүү дээ хууль дээдэлнэ гэдэг ийм Үндсэн хуулийн заалт байгаа. Тэрийг нэг ч удаа бид хэрэглээгүй. Тэгээд Үндсэн хуульд хэчнээн нэмлээ ч бас ялгаагүй. Би тэрэнд бол эргэлзэх юм алга. Тийм учраас зүгээр ер нь ялангуяа энэ лидерүүд ном толгойлж байгаа улсууд, засаг толгойлж байгаа улсууд, төрийн 3 өндөрлөгт ажиллаж байгаа улсууд эд нар бол энийг дагах тийм ёс зүй, хариуцлагаа ухамсарласан ийм л байдал шаардлагатай юм болов уу гэж би зүгээр бодож байгаа юм.

Тэрнээс биш бол бид нар жишээлбэл эрчим хүчний асуудал битгий хэл юмаа шийдчих их мөнгийг. Би одоо жишээлбэл халамжийн мөнгө дээр хэлээд байгаа шүү дээ. Нэг суманд нэг тэрбум төгрөгийн 5-8 үйлдвэр барих мөнгийг бид нар идээд байна шүү дээ гэж. Хэрэв ингэдэггүй байсан бол, ингэдэггүй удирдагч нартай байсан бол бид нар өнөөдөр ажилгүйдэл гэдэг юм уу, энэ хямрал гэдэг юм байхгүй шүү дээ. Тэр суманд чинь үйлдвэрлэл явж байгаа, хөдөө аж ахуйн үйлдвэр, арьс шир боловсруулах янз бүрийн үйлдвэрлэл тэнд байгуулах боломж байна шүү дээ.

Гэхдээ бид нар тэгэхгүй байна шүү дээ. Энд чинь л асуудал байгаа байхгүй юу. Энд л худлаа нэг хууль яриад л байдаг. Би энэ төлөвлөлтийн хуулиас бүр залхаж байна. Би арван хэдэн жил энийг чинь ярилаа. Арван хэдэн жил ийм юмнууд хийлээ. Тэгээд өөрчлөгдсөн юм бол алга байгаад байгаа шүү дээ. Бидэнд байгаа хуульд биш, бүтцэд биш. Бидэнд байгаа. Бүтэц байгуулаад өгөхөөр яасан бэ замын уулзвар байгуулдаг яам болгоод хаячихсан шүү дээ. Тийм биз. Тэгэхээр хүндээ байгаа байхгүй юу. Бидэндээ байгаа байхгүй юу. Энэ улс төрчдөд байгаа байхгүй юу. Энийгээ л одоо бид нар сайн тал бүр дээр ойлгож ухамсарладаг болох юм бол.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явна.

Байнгын хорооны саналаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 52 хууль байсан билүү? 52 хуулийг батлах тухай санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

Байнгын хорооны саналаар Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 1.Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 2.Авто замын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 3.Агаарын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 4.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 5.Ахмад настны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 6.Аялал жуулчлалын тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай, 7.Биеийн тамир, спортын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 8.Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 9.Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 9.Баяжуулсан хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 10.Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 11.Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 12.Гамшгаас хамгаалах тухай тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 13.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 14.Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 15.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 16.Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 17.Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 18.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 19.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 20.Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 21.Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 22.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 23.Мал амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 24.Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 25.Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 26.Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 27.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 28.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 29.Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 30.Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 31.Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 32.Ойн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 33.Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 34.Статистикийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 35.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, 36.Тусгай хамгаалалтын газар нутгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 37.Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 37.Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 39.Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 40.Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, 41.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 42.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, 43.Хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 44.Хэмжил зүйн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай, 45.Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 46.Цөлжилтөөс сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 47.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 48.Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 49.Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай,

50.Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 51.Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураана. Дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

55 гишүүн дэмжиж 83,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна. Эдийн засгийн байнгын хорооноос энэ хоёр хуулийг нийлүүлж хэлэлцүүлэхээр ажлын хэсэг ажиллана. Энэ ажлын хэсгийг өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Содномын Чинзориг гишүүн ахалж ажиллана. Байнгын хороо тэгж шийдвэрлэсэн. Дараагийн асуудалд орно.

**Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.**

Тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын эрхэм гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг танилцуулна.

**Ц.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос боловсруулж 2021 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд, түр хороо болон хууль санаачлагчийн саналыг үндэслэн хуулийн зохицуулалтын дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс 20, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс 18, Улсын Их Хурлын 11 Байнгын хорооноос 62, Улсын Их Хурлын гишүүдээс 9, Засгийн газраас 136 санал нийт 245 хууль тогтоолын төслийг тогтоолын төсөлд тусгуулах саналаа албан бичгээр ирүүлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулахдаа дараах зарчмыг баримталсан болно. Үүнд:

1.Намрын ээлжит чуулганаар хэлэлцэн батлахаар хуульд тусгайлан заасан хууль тогтоомжийн төслүүд.

2.Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2020 оны 2 дугаар тогтоолын хавсралтад заасан Монгол Улсын Үндсэн

хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулах шаардлагатай хуулийн төслүүд.

3.Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр тэргүүн ээлжид хэлэлцэх хууль тогтоолын төслүүдийг тусгах зарчмыг баримтлан нийт 73 төслийг тогтоолын төсөлд тусгалаа.

Тогтоолд тусгаснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх эсэх асуудлыг тухай бүрт нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7 дэх хэсэгт заасны дагуу шийдүүлж байхаар тогтоосон.

Түүнчлэн ковид-19 цар тахлын үеийн нөхцөл байдалтай холбоотойгоор Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг тухай бүрт хэлэлцэхээр тогтсон болно. Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон Байнгын хорооны санал, дүгнэлтийг та бүхэнд тараасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүнээр тасаллаа. Цахимаар 1 гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Жигжидийн Батжаргал асуулт асууж, үг хэлнэ.

**Ж.Батжаргал:** 2, 3-хан асуулт байна. 1 дүгээрт бид энэ төсвөө эрүүлжүүлэх хүрээнд халамжаас хөдөлмөрт гэсэн нэг ийм том бодлого бариад яваад байгаа юм улсууд. Тийм учраас энэ чиглэлээр Их Хурлаас бодлогын ямар баримт бичиг гарч түүнийгээ дагуулж эрх зүйн зохицуулалтуудаа хийх ёстой юм бэ, энэ намрын чуулганаар орох ёстой юм биш үү гэдэг нэг асуудал байна.

Дараагийн асуудал энэ Хөнгөн үйлдвэрийн, Хүнд үйлдвэрийн тухай хуулиуд чинь намрын чуулгандаа орж ирж батлагдаж байж 22, 23, 24 онуудад хэрэгжиж байж 24 онд үр дүн нь гарч ирэх юм биш үү. Тийм учраас энэ хуулиудыг нааш нь татаж хэлэлцэх тухай асуудал байна уу? Энэ жагсаалтад байхгүй юм шиг харагдаад байх юм. Ийм 2 асуулт байна.

**Г.Занданшатар:** Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Жамъянгийн Мөнхбат асуултад хариулна. Халамжаас бүтээмж рүү шилжсэн.

**Ж.Мөнхбат:** Батжаргал гишүүний ярьж байгаа зүйл бол үндсэндээ бас энэ хэлэлцэх асуудалд байгаа гэж ойлгож болно. Ер нь бол манай гишүүдэд мэдээлэл өгөхөд нийтдээ 245 хууль, тогтоолын төслийг энэ тогтоолын төсөлд тусгуулах саналаа албан бичгээр ирүүлсэн. Бид нар бол шинэ хуулийн дагуу, шинэ Дэгийн хуулийн дагуу бол ирэх чуулганаар хэлэлцэх асуудлаа ингэж баталж хэлэлцдэг хуультай болсон.

Чуулган завсарлахаас одоо долоо хоногийн өмнө хугацаатай хуулийн Төрийн байгуулалтын байнгын хороонд албан бичгээр ирүүлэх ёстой гэсэн ийм зүйлийн дагуу бол Байнгын хороод Ерөнхийлөгч, Засгийн газрын зүгээс бол саналууд ирсэн. Ингээд зарим нэр бүхий Улсын Их Хурлын гишүүд ирсэн. Ирүүлсэн байж байгаа. Саяын энэ хөнгөн үйлдвэрлэлийн тухай хуулийн төсөл, Хууль тогтоомжийн тухай хууль, Хүнд үйлдвэрлэлийн тухай хуулийн төсөл гээд ингээд энэ хэлэлцэх асуудлуудын дараалалд орж байгаа төсөвтэй холбоотой энэ асуудал, саяын энэ Батжаргал гишүүний яриад байгаа асуудал бол тусаад явж байгаа гэж бас ойлгож болно.

Дээрээс нь хэлэлцүүлгийн шатанд байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслүүдийг үргэлжлүүлэн хэлэлцүүлнэ гээд энэ тогтоолд орсон байж байгаа. Өөрөөр хэлэх юм бол хэлэлцэх эсэхийг нь шийдсэн байж байгаа хуулийн төслүүд бол энд бас ороод явж байгаа. Бусад төслүүдийг бол Даргын дэргэдэх зөвлөл дээр тухайн үед нь өргөн баригдсаны дараа өргөн баригдаад ингээд хэлэлцээд явдаг энэ Дэгийн хуулийн зохицуулалттай байгаа.

Тэгэхээр энүүгээрээ бол ингээд явах бүрэн боломж байгаа шүү гэдгийг хэлье. Ер нь бол энэ жил нөгөө Дэгийн хууль өнгөрсөн жилээс бол шинээр мөрдөж эхэлсэнтэй холбоотой манай бас холбогдох саналаа ирүүлэх албан ёсоор албан бичгээр ирүүлэх энэ газрууд маань бас оройтож хоцруулж ирүүлсэн тал бий. Тэгэхээр бол энэ цаашлаад энэ намрын чуулган.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Цахимаас 2 гишүүн, цахимын гишүүд дотогшоо ороод ирээд байдаг. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн. Оюунчимэг гишүүн.

**Ж.Бат-Эрдэнэ:** Баярлалаа. 2 асуулт байна, юу хууль тодруулах гэсэн юм. Авто тээврийн тухай хууль, Төмөр замын тухай хуулиуд орсон уу? Энийг лавлая. Энэ Байнгын хороон дээрээс юу орж ирээгүй байх юм. Жагсаалтууд орж ирээгүй байгаад байх юм. Мунparliament-аас би бас хайгаад ерөөсөө наана чинь орж ирсэнгүй. Тэгээд Авто тээврийн тухай хууль, Төмөр замын тухай хуулиуд орж ирсэн үү энийг лавлаж байна. Хэлэлцэх хуулиудын жагсаалтад дотор байна уу гэж.

**Г.Занданшатар:** Байнгын хорооны дарга Жамъянгийн Мөнхбат хариулна.

**Ж.Мөнхбат:** Бат-Эрдэнэ гишүүний асууж байгаа хуулиуд ирэх жилийн намрын чуулганы хэлэлцэх асуудалд байгаа гэж ойлгоорой. Орсон байгаа.

**Г.Занданшатар:** Эрхэм гишүүн Ёндонпэрэнлэйн Баатарбилэг.

**Ё.Баатарбилэг:** Гишүүдийнхээ өглөөний амрыг айлтгая. Тэгэхээр намрын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад Улсын Их Хуралд өргөн бариад хэлэлцэх эсэхийг нь шийдсэн байгаа 2 хуулийн талаар бас хэлье гэж бодож байна. Боловсролын салбарын багц хууль явж байгаа хэлэлцэх эсэх нь шийдэгдсэн.

Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуулиуд байж байгаа хэлэлцүүлгийн шатанд явж байгаа. Энэ хуулиуд нэр заагдаж энэ жагсаалтад ороогүй. Өчигдөр Байнгын хорооны хурлаар хэлэлцэж байх үед энэ хуулиудыг Их Хурлын хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Засгийн газар, Их Хурлын гишүүдийн өргөн мэдүүлсэн хэлэлцүүлгийн шатанд байгаа хуулиуд бол жагсаалтад намрын чуулганы хугацаанд хэлэлцэгдээд явах боломжтой гэсэн энэ хариултыг өгсөн учраас энийг бас өнөөдөр протоколд тэмдэглүүлээд хэлэх нь зүйтэй.

Боловсролын салбарын багц хууль бол яах аргагүй энэ намрын чуулганы нэг том гол хуулиудын нэг байж явах учиртай. Багшийн хөгжлийн талаарх багшийн хөгжилтэй холбоотой, багшийн тэтгэврийн нас, тэтгэмж, урамшуулал, багшийн ажиллах орчин нөхцөл, эцэг, эхчүүдийн, боловсролын байгууллагын гээд цогцоор нь шинэчилсэн найруулга орж байгаа. Тэгэхээр энийг бол цаг алдалгүй энэ намрын чуулганаар батлах нь зүйтэй гэж ингэж үзэж байгаа.

Боловсролын салбарын багц хуулийг дагаж орж байгаа Дээд боловсролын хууль, энэтэй уялдуулж энэ хуулийг гарсны дараа энэ Шинжлэх ухаан, технологийн хууль, энэ судалгаатай холбоотой, шинжилгээтэй холбоотой энэ байгууллагуудын асуудлыг боловсролын багц хуулийн араас залгуулж бас концепцыг уялдуулж батлах зүйтэй гэсэн ийм байр суурь барьж энэ шинжлэх ухааны салбарын хуулийн ажлын хэсгийг ахалж байгаа гишүүний хувьд бас ийм байр суурийг илэрхийлж байгаа.

Тэгээд намрын чуулганы хугацаанд энэ хуулиудыг бол бас хэлэлцэх асуудалд оруулаад явах болно. Энэ дээр бас гишүүд маань бас дэмжинэ байх гэж бодож байна. Ийм үг хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн үг хэллээ. Цахимаар өөр хэн байгаа билээ? Цахимаар алга байна. Эрхэм гишүүний Бөхчулууны Пүрэвдорж.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр энэ хаврын чуулган бол нэлээн онцлогтой. Ялангуяа одоо хүний эрхийг дээдэлсэн хэд хэдэн чухал алхмуудыг хийсэн. Өөрөөр хэлбэл Хүний эрхийн Үндэсний Комиссыг олон нийтийн хэлэлцүүлгийг үр дүнд томилж илүү одоо шуурхай ажиллах ийм боломжийг нь бүрдүүлж өгсөн. Мөн түүнчлэн хүний эрхийг дээдэлсэн хуулийн тогтоомжуудыг гаргасан байгаа. Тийм учраас энэ хаврын чуулган бол нэлээн хүний эрх талдаа л нэлээн сайн ажилласан гэж би үзэж байгаа.

Тэгэхээр намрын чуулгандаа хүнээ дээдэлсэн ийм Их Хурлын чуулган болох хэрэгтэй байна. Ингэхийн тулд бас тодорхой хэмжээгээр би жишээ нь Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тэтгэмж олгох тухай хуулийн төслийг өргөн барьсан. Энэ хуулийн дагуу бол 7 жилийн дундаж цалингийн дунджаар тэтгэвэр тогтоодог байгааг 5 жил болгохгүй бол энэ шударгаар нийгмийн даатгалын шимтгэл төлсөн тэр хүмүүсийн тэтгэвэр авахдаа хохироод байна. Өөрөөр хэлбэл 7 жил болгохоор ойролцоогоор 100-аад мянган төгрөгөөр дунджаар бага тэтгэвэр аваад байгаа юм.

Тийм учраас Одонтуяа, Бейсен бид гурвын өргөн барьсан энэ одоо 5 жил болгох хуулийн төслийг Байнгын хороон дээр санал хураалгасан боловч олонхын санал авч чадаагүй. Энийг одоо нэмж тусгаж өгөх талаар гишүүд анхаарахыг хүсье. Байнгын хороон дээр бол миний бас өргөн барьсан Нэмэгдсэн өртгийн

албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулж 10 хувийг 5 хувь болгох уул уурхай, архи, тамхи энэ онцгой татвартай бүтээгдэхүүнээс бусдыг нь 5 хувь болгох энэ хуулийн төслийг Байнгын хорооны гишүүд дэмжиж оруулж өгсөн байгаа. Тийм учраас манай гишүүд тэр 7 жилийг 5 жил болгох.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Пүрэвдорж гишүүн нэг минут.

**Б.Пүрэвдорж:** 7 жилийг 5 жил болгох энэ хууль бол манай энэ тэтгэвэрт гарч байгаа төрд ажиллаж байгаа, хувийн хэвшилд ажиллаж байгаа тэр хүмүүсийн хувьд бол хамгийн урам зоригийг нэмсэн, амьдралынх нь баталгааг хангасан ийм одоо хууль болох ёстой шүү гэдгийг хэлье. Тэгээд Байнгын хорооны даргаас асууя. Одоо энэ зарчмын зөрүүтэй саналаар энэ миний унасан энэ саналыг энэ чуулганы танхим дээр хураалгах уу, хураах тохиолдолд одоо ямар байр суурьтай байгаа вэ гэдгийг танаас асууя.

**Г.Занданшатар:** Жамъянгийн Мөнхбат гишүүн асуултад хариулна. Байнгын хорооны дарга хариулъя.

**Ж.Мөнхбат:** Пүрэвдорж гишүүний ярьж байгаа энэ зарчимтай бол снаал нийлж байгаа юм. Энэ хүний эрхийг дээдлэх, ер нь бол төр хүнийхээ төлөө хүн төвд төрийн бодлого бид нар зарчим баримтална гэж байгаа. Энэ дээр бол бас санал нэг байгаа. Ер нь бол 3 янзын энэ хуулиуд орж ирж байгаа. Намрын ээлжит чуулганаар хэлэлцэн батлахаар хуульд тусгайлан заасан хууль тогтоомжууд орж ирж байгаа. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт түүний тогтоомжид нийцүүлэх түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний гээд Улсын Их Хурлын 20 оны 02 дугаар тогтоол 30 гаруй хуулийг бид нар ярина.

Ерөнхийлөгчийн хуулиас авхуулаад. Дараа нь энэ хэлэлцүүлгийн шатанд байгаа хууль, тогтоолын төслийг үргэлжлүүлэн хэлэлцэнэ гээд тогтоолын төслийн 2 дахь заалтад ингээд тусгасан. Пүрэвдорж гишүүний энэ түрүүний энэ ярьж байгаа яах вэ Байнгын хороон дээрээ зарчмын зөрүүтэй санал гаргаад дэмжигдээгүй юм шиг байгаа юм. Тэгж ойлгосон. Тэгээд энэ асуудлыг бол бид нар цаашдаа намрын чуулганаар хэлэлцээд явах бол боломж байгаа шүү дээ. Одонтуйаа гишүүн байж байна. Даргын зөвлөл дээрээ ч гэсэн тухайн үед нь ямар, ямар хуулиудаа явуулах гэдгийг Даргын зөвлөл дээрээ яриад ингээд шийдээд явчихдаг бас ийм дэгийн зохицуулалт зарчмууд байж байгаа.

Тэгэхээр энэ асуудал намрын чуулган дээр ингээд хангагдаад явах боломжтой гэж үзэж байгаа. Гол нь одоо таны оруулсан асуудал Байнгын хорооноосоо олонхын санал дэмжлэгээ л одоо авсан байх хэрэгтэй.

**Г.Занданшатар:** Баагаагийн Баттөмөр гишүүн. Цахим дээр ч таны нэр байхгүй л байна л даа.

**Б.Баттөмөр:** Энэ шинэ Үндсэн хуультай холбогдуулаад хуульд өөрчлөлт шинэчлэлт хийх шаардлага бол их өндөр байгаа юм. Энэ одоо жагсаалтыг сая авлаа. Тэгээд энэ дээр бодох тийм боломж байсангүй харамсалтай нь. Мэдээж энэ оруулж ирж байгаа энэ хуулийн төслүүд бол өргөн баригдсан хуулийнхаа хүрээнд л ярьж байгаа байх л даа. Гэхдээ өнөөдөр өргөн бариад маргааш нь бид нар хэлэлцээд явж байдаг энэ практик байна шүү дээ. Тэгэхээр энэ одоо үйлчилж байгаа энэ хуулиудтай энэ шинэ Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбогдуулаад энэ

завсарлагааны хугацаанд маш сайн шүүлт хийж, намрын чуулганаар нэмж тодотгох нь бол зүйтэй гэсэн ийм саналыг би хэлж өгч байгаа юм.

Энэ хэд хэдэн их зарчмын сайн хуулиудыг ингэж яах юм байна л даа. Гаалийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль гээд үнэхээр чухал шаардлагатай өөрчлөлт шинэчлэл хийх хуулиуд бол энэ дотор байна. Энийг хэлэхийг хүсэж байна. Энэ дээр огт ороогүй байгаа хэд хэдэн анхаарал татсан хуулиуд байна л даа. Тухайлбал энэ Худалдааны хууль байгаа юм. Монгол Улс 30 жил хөгжихдөө Худалдааны хуульгүй л өнөөдөр явж байна. Хүн болгон дуртай зүгтээ валют халаасалж аваад бараа оруулж ирдэг.

Дотоодын одоо зах зээлээ хамгаалах ийм бодлого байдаггүй. Ийм учраас энэ намрын чуулганаар энэ Худалдааны хуулийг зайлшгүй батлах ийм шаардлагатай гэсэн ийм саналыг би хэлэх гэж байгаа юм. Дараагийн асуудал бол энэ эрсдэл гэж. Эрсдэл хэлж ирдэггүй, хэнийг ялгадаггүй. Та эрсдэлээ удирдахгүй бол таныг эрсдэл удирдана гэсэн үг байдаг. Ийм учраас энэ Монгол Улсад эрсдэлийг удирдах тухай хуулийг гаргаж ирмээр байна. Ийм боломж байна уу үгүй юу гэсэн энийг би хэлэхийг хүсэж байна. Ийм учраас энэ оруулж ирж байгааг бол батлаад дахиад намар энэ дээрээ тодотгол хийх нь зүйтэй гэсэн ийм.../минут дуусав/

**Г.Занданшатар:** Баттөмөр гишүүн үг хэллээ.

Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Пүрэвдорж гишүүн бас чухал санаа хэллээ. Энэ чуулган бол хүний эрх, ардчиллын чуулган болж чадлаа гэж бас. Намрын чуулганы хуралдааныг дүгнэсэн явдал бол бас цөөхөн бүлгийн сайн тодорхойлолт байлаа гэж бодож байна. Ингээд Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт.

50 гишүүн дэмжиж 75,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын төсөл батлагдлаа.

Батлагдсан хууль, Улсын Их Хурлын тогтоолуудын эцсийн найруулгыг сонсоно. Тэрнээс өмнө энэ зарим мэдээллийг бас танилцуулъя. Эрхэм гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг нарын гишүүд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд баталсантай холбогдуулан хуулийн төслийг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 23 дахь хэсэгт заасныг үндэслэн төслөө татан авах саналыг хүргүүлж байна гэсэн байна. Энэ гишүүдийн хуулийг татан авсан болохыг мэдэгдье.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг нарын гишүүд цөлжилтөөс сэргийлэх, ногоон хөгжлийг дэмжих, байгаль орчныг хамгаалах чиглэлээр лобби бүлэг байгуулах болсноо мэдэгдсэн албан бичгийг Цэдэндамбын



Цэрэнпунцаг нарын гишүүдийн бүлэг байгуулснаа зарлаж өгөхийг хүссэн албан бичиг ирснийг зарлан мэдэгдэж байна.

**Баталсан хууль, тогтоолуудын эцсийн найруулгыг сонсоно. Улсын Их Хурлын Тамгын газар энэ юуны үед бид нар эрчтэй ажиллаж 81 хуулийн эцсийн найруулгыг уншлаа. Зөрчил алдааг бас үг үсгийн алдааг засаж эцсийн найруулга хийснийг уншиж танилцуулъя.**

1.Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Энэ чуулганы дэгийн тухай хуулийн 45.1.4-т заасны дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 158 дугаар зүйлийн 158.1.1 дэх заалтын 154.8 гэсний өмнөх 154.2 гэснийг хасах найруулгын санал гаргаж байгаа. Энэ нь нөгөө төслийн бүлэг зүйл заалтын дугаар өөрчилсөнтэй холбоотойгоор 158 дугаар зүйлд оруулсан эшлэлүүд өөрчлөгдсөн учраас ийм зайлшгүй шаардлага байгаа юм.

**Г.Занданшатар:** Протоколд тусгаж хэллээ энийг. Эцсийн найруулга дээр энэ саналыг авлаа. Дагалдан гарсан Хөдөлмөрийн тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Эрхэм гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг эцсийн найруулга дээр.

**М.Оюунчимэг:** Түрүүний яг хэлсэн 45.1.4-т заасны дагуу Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгээр 61<sup>1</sup> дүгээр зүйлийг хассантай нийцүүлэн төслийн 6 дугаар зүйлийн 61.1.6 дахь заалт мөн хасагдана. Иймд энэ техникийн засварыг найруулгаар авах саналыг гаргаж байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Хууль зүйн техникийн засварыг найруулгаар авах асуудлыг судлан шинжилж шийдье. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

4.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

5.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонслоо.

6.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонслоо.

7.Төрийн албаны тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулга сонссонд тооцлоо.

8.Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

9.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонслоо.

10.Боловсролын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

11.Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонслоо.

12.Донорын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

13.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

14.Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

15.Төмөр замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

16.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

17.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Мөнх-Оргил гишүүн үг гэж бичсэн байх юм энэ юун дээр үг? Энэ чинь. Оюунчимэг гишүүн хэлсэн байна Мөнх-Оргил гишүүнээ. Хоцорч ирлээ. Сонссонд тооцлоо.

18.Холбогдуулан боловсруулсан Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

19.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

20.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

21.Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

22.Эх, эцэг олон хүүхэдтэй өрх толгойлсон хүүхэдтэй эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

23.Хөдөлмөрийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

24.Хуулийн төсөл буцаах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

25.Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

26.Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

27.Кино урлагыг дэмжих тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

28.Дагалдан гарсан Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

29.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

30.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

31.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

32.Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

33.Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

34.Соёлын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

35.Дагалдан гарсан Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

36.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

37.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

38.Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонслоо.

39.Гэр бүлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

40.Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

41.Номын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

42.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

43.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

44.Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

45.Хуулийн төсөл буцаах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

46.Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

47.Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

48.Дагалдан гарсан Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

49.Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

50.Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

51.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

52.Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

53.Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

54.Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

55.Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

56.Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

57.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

58.Нийслэл хотын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

59.Монгол Улсын авто тээврийн болон хуурай явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

60.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

61.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

62.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

64.Хот байгуулах тухай тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

65.Холбогдуулан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах

тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

66.Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

67.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

68.Дагалдан гарсан Төсвийн зарим тусгай шаардлагын үйлчлэлийг түр түдгэлзүүлэх, мөрдөх хугацааг хойшлуулах тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

69.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

70.Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

71.Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

72.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

73.Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

74.Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

75.Үндсэн хуулийн цэцийн гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

76.Прокурорын ажлын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

77.Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

78.Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

79.Монгол Улсын Их Хурлаас албан тушаалтныг томилохтой холбогдуулан томилгооны сонсгол зохион байгуулах журам батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

80.Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

81.Монгол Улсын Их Хурлын 2021 оны намрын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо.

63.Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Сонссонд тооцлоо. Хуулиудын эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэн нарын гишүүдээс Оюу толгойн асуудлаарх Улсын Их Хурлын тогтоолын Оюу толгойн төсөлд Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийг хянан шалгах тухай түр хорооны хугацаагаа сунгасан болохыг мэдэгдсэн албан бичиг ирүүлсэн байна. Ингээд үүнийг зарлан мэдэгдэж байна. Танилцуулж байна. Түр хороо нэг чуулганы хугацаанд ажиллаад дахин нэг чуулганы хугацаанд сунган ажиллаж болно гэсэн заалтыг үндэслээд сунган ажиллах болсон байна.

**Улсын Их Хурлын 2021 оны хаврын ээлжит чуулган өндөрлөх гэж байна.**

Ингээд хаалтын үг хэлье.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нар хур тэгширч, нам төр цэгцэрсэн, байгаль дэлхий өгөөжөө хайрласан зуны энэ сайхан өдөр 2021 оны хаврын ээлжит чуулган өндөрлөж байна. Коронавирусийн цар тахал улс орон, иргэдийн амьдралд хүнд эрсдэл дагуулсан амаргүй цаг үед дэлхий даяараа дэлхийн парламентууд хүнд сорилт дэвшилттэй тулгарч хуралдаан чуулгануудаа хойшлуулж, дэг журмаа өөрчилж зарим бол ихэнх нь энэ цахим зайнаас хуралдах дэг журамд шилжиж байна. Монгол Улсын Их Хурал бол хаврын чуулганы хугацаанд цахимаар хуралдаж, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу анх удаа 75-аас дээш өдөр хуралдлаа. Үндсэндээ 83 өдөр чууллаа.

Энэ удаагийн чуулганы нэгдсэн хуралдаан 34 удаа хуралдаж, 188 асуудал хэлэлцсэн, Байнгын хороодын хуралдаан 110 удаа, Дэд хороод 6 удаа, Түр хороод

13 удаа буюу нийт 127 удаа бид хуралдсан байна. 247 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Нийт хуралдааны хугацаа 317 цагт хүрч, 462 асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ. Энэ бол бас их амжилт юм. Хуралдаан чуулган яг цагтаа эхэлж, өнгөрсөн 30 жилийн парламентын түүхэнд хоцрогдол, таслагдалгүй, хамгийн өндөр амжилт үзүүлсэн ийм чуулган боллоо. Хаврын чуулганы энэ хугацаагаар энэ амжилт бол энэ үр дүнд нийт 162 хууль тогтоомж баталсан байна. Бие даасан хууль 16 хуулийг дагалдах хуулиудтай нь, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 84, хууль хүчингүй болсонд тооцох тухай 7 хууль олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай хууль 3, Улсын Их Хурлын 52 тогтоол, нийт 162 хууль тогтоомж батлан гаргалаа.

Хэдийгээр хуралдааны танхимдаа чуулж, шинжлэх ухаанч нүүр халз мэтгэлцээн, ажил хэрэгч яриа хөөрөө өрнүүлэх боломж цар тахлын улмаас хумигдсан ч цахим хуралдаандаа өндөр ирцтэйгээр, идэвхтэй оролцож, өндөр ачаалалтай ажилласан Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ талархал илэрхийлье. Энэ удаагийн чуулган юуны өмнө манай энэ Пүрэвдорж гишүүн цөөнхийн бүлгээс тодорхойлсончлон хүний эрх, ардчиллыг бэхжүүлэхэд чиглэсэн чуулган боллоо гэж хэлж болно. Монгол хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дугаар тайланг Хүний эрхийн Үндэсний Комиссын тайланг хэлэлцээд Улсын Их Хурал анх удаагаа энэ тайлангийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол баталлаа. Тогтоолд болон Улсын Их Хурлын чуулганы үзэл санаа, үзэл баримтлалд Монгол хүний эрхийг хуульчлан хамгаалах, хууль болгонд хүний эрхийг амин сүнс болгон тусгах, хүний эрхийн мэдрэмжтэй парламент байх талаар хаврын чуулганы эхэнд дэвшүүлсэн зорилтоо бид бодит алхмуудаар хэрэгжүүлж чадлаа.

Хүний эрхийн сэдвээр нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлыг бие даасан хуулиар баталгаажууллаа. Хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдлыг хангах, хүний эрхийн зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх шинэ тогтолцоог бүрдүүлсэн. Түүнчлэн Хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах хороог ХЭҮК-ын дэргэд байгуулахаар тусгайлан зааж өглөө. Иргэдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хилс хэргээр яллахгүй байх, эрүүдэн шүүлтийг таслан зогсоох чиглэлд зарим бодит эхлэл гарч эхэллээ. Цаашид идэвхтэй мөрдөгдөж буй 400 гаруй хуульд хүний эрхийн талаас үнэлгээ хийж, хэрэв эдгээр хуульд ямар нэгэн байдлаар хүний эрхийг зөрчсөн зүйл, заалт байвал даруй өөрчлөн шинэчлэх нь та бидний ирэх намрын чуулганы зорилт байх болно. Энэ эхлүүлсэн ажлаа бид тууштай үргэлжлүүлнэ. Тууштай үргэлжлүүлнэ.

Ингээд Хүний эрхийн Комиссын гаргасан тайлан дүгнэлттэй холбогдуулж коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны явцад хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр Засгийн газарт тодорхой үүрэг, чиглэл өглөө. УОК-оос хүний эрх, эрх чөлөөнд тодорхой хязгаарлалт хийх аливаа шийдвэр гаргахдаа ХЭҮК-оос заавал заавар зөвлөмж авдаг байх, иргэдтэй хүнлэг бус харилцах, ялгаварлан гадуурхсан шинжтэй үйлдэл, шийдвэр гаргах, Монгол Улсын хуульд заасан иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхийг зөрчих аливаа үйлдлийг таслан зогсоох ёстой гэж Улсын Их Хурал үзсэн.

Түүнчлэн эрүүл мэндийн зөвлөмж, үйлчилгээ болон эмчилгээний арга, эмийн талаар мэдээллийг тэгш хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар иргэдэд хүргэх, дархлаажуулалтад хамрагдсан эсэхээс үл хамаарч төрийн үйлчилгээ авах эрхийг нь бүрэн хангах, сурч боловсрох эрх нь зөрчигдөж буй сурагчдын сурлагын



хоцрогдлыг чанар сайтай нөхөж олгох зэрэг арга хэмжээнүүд энэхүү тогтоолд тусгагдсан.

Хоёрдугаарт, энэ чуулган Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулах эрхэм зорилгодоо, эрх зүйн хувьсгалыг эхлүүлж хэрэгжүүлэх амжилттай томоохон алхам хийсэн чуулган боллоо. Улсын Их Хурал Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуулийг шинэчлэн батлаад энэ үндсэн дээр 27 жилийн дараа нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн орчныг шинэчиллээ. 27 жилийн хугацаанд Улаанбаатар хот яаж өөрчлөгдсөнийг хүн бүр мэдэж байгаа. Энэ бол Үндсэн хуульд нутгийн удирдлагыг боловсронгуй болгох талаар оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Улаанбаатар хотод бодит ажил болгон хэрэгжүүлэх, тулгараад байгаа түгжрэлээс эхлээд төвлөрлийг сааруулах, бэрхшээлтэй олон асуудлыг шийдэх эрх зүйн томоохон шинэчлэл болсон гэж үзэж байна. Улсын Их Хурлаас 1994 онд баталсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль нь өнөөгийн нийслэл хотын эрэлт хэрэгцээ, цаг үеийн шаардлагыг хангахгүй болсон нь нэгэнт тодорхой байсан.

Энэ хуулиар нийслэлийг нийслэл хотод хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн, олон төвтэй төвлөрлийг сааруулсан, олон улсад өрсөлдөх чадвартай, иргэд, олон нийтийн оролцоонд тулгуурласан, сайн засаглал бүхий аялал жуулчлалын томоохон төв болгож хөгжүүлэх нь нэн чухал байгаа энэ зорилтдоо нийцүүлсэн. Иймээс нийслэл хотын онцлог, цаашдын хөгжлийн загвар, улс орны хөгжилд гүйцэтгэх үүргийг шинээр тодорхойлж, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай уялдуулах зайлшгүй шаардлагын үүднээс Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлыг хуульчлан баталлаа. Үүгээрээ хүн амын хэт их төвлөрөл, эмх замбараагүй газар олголт, төлөвлөлтийг зөрчсөн барилгажилт, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн хүртээмж хангалтгүй болж, айл өрх, орон сууц, аж ахуйн нэгж, байгууллагыг цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны тогтвортой эх үүсвэрээр хангах, замын түгжрэл түгжрээ, орчны бохирдлыг бууруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зэрэг тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх боломжийг эрх зүйн хувьд энэ хуулиар нээсэн. Тиймээс Улаанбаатар хотын хөгжлийн хийгээд хот төлөвлөлтийн бодлогыг шинээр тодорхойлох асуудлыг Улсын Их Хурлын түвшинд авч үзэж, шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж Нийслэл хотоос сонгогдсон гишүүд санаачлан Улаанбаатар хотын хөгжлийн бодлого эрхэлсэн Түр хороог байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын төслүүд Улсын Их Хуралд өргөн баригдаж, хэлэлцэх эсэхийг шийдвэрлээд Ажлын хэсгийг байгууллаа. Энэ бол парламентад ёс бүтэн болох тийм том суурь хууль. Сонгодог парламентын засаглалаа бэхжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлсэн энэ чухал хууль бол ирэх намрын чуулганаар хэлэлцэн батална. Ингэснээр Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүрэг шинэ шатанд гарч, хариуцлага сахилга, ёс зүйн тогтолцоо төгөлдөржиж, нийгэмд шударга ёс тогтооход томоохон ахиц дэвшил гарна гэж үзэж байна.

Гуравдугаарт, энэ удаагийн чуулган иргэнийхээ хөдөлмөрлөх эрхийг хангасан, халамжаас хөдөлмөрт шилжих шинэ харилцааг дэмжсэн чуулган боллоо. Монгол Улсын хөдөлмөрийн харилцааны өнөөгийн байдал, үндэсний онцлог, хөдөлмөрийн зах зээлийн цаашдын хөгжлийн чиг хандлагад нийцүүлж, Монгол Улсын 1,1 сая ажиллагчид, нийт ажил олгогчдын хөдөлмөрийн харилцааг зохицуулах Хөдөлмөрийн хуулийн шинэчилсэн найруулгаар бид баталсан. Энэ хуулиар хөдөлмөр эрхлэлтийн гурвалсан харилцаа, цагаар ажиллах, гэрээсээ,

зайнаас ажиллах, уртын ээлжээр ажил, үүргээ гүйцэтгэх, туслах малчнаар ажиллах зэрэг хөдөлмөрийн харилцааны шинэ хэлбэрүүд зохицуулагдсан.

Түүнчлэн ажил олгогч болон ажилтны хөдөлмөрийн харилцаан дахь эрх, хүлээх үүргийг зохистойгоор тэнцвэржүүлсэн. Хөдөлмөрийн гэрээний зохицуулалтыг боловсронгуй болгосон. Цалин хөлсийг гүйцэтгэл, бүтээмж, ур чадвартай нь уялдуулах, нарийн мэргэжлээр дагалдангаар ажиллах, дагалдангаар суралцах зэрэг нарийвчилсан зохицуулалтыг тусгаснаар үндэсний ажиллах хүчний өрсөлдөх чадвар, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд энэхүү хууль чухал ач холбогдолтой болсныг онцлон тэмдэглэж байна.

Хоршооны тухай хуулийг баталсан нь хоршооны хөгжлийг шинэ түвшинд гаргах эрх зүйн үндэс болж, хоршоо бие даан хөгжих нөхцөл хангагдах, хоршин, хамтарч ажиллах замаар ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна. Цаашлаад үнэгүйдээд байгаа малын гаралтай түүхий эд, арьс шир, ноос ноолуур, түүхий эд бэлтгэлийн болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлд нийлүүлэх шинэ тогтолцоо бий болгож, малчид, тариаланчдын амьдрал ахуйг сайжруулах, үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ажилгүйдлийг бууруулахад энэ хууль чухал ач холбогдолтой болно гэдэгт эргэлзэхгүй байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, Хоршоог хөгжүүлэх сан байгуулах, уг сангаас хөнгөлөлттэй зээл олгох, ИТХ орон нутагтаа хоршоог хөгжүүлэх хөрөнгийг жил бүр төсөвтөө тусгаж батлах зэрэг зохицуулалтыг энэхүү хуулиар бүрдүүлж өгсөн. Эцсийн дүндээ орон нутгийн хөгжлийг дэмжих, халамж тэтгэмжид биш, хөдөлмөрт суурилсан бүтээгч үйлдвэрлэгч ард түмэн болоход энэ хууль чухал үүрэг гүйцэтгэх учиртай.

Түүнчлэн 2017 онд баталсан Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ тус бүр 7 хувь байсныг өөрчлөн 9,5 хувьд хүргэсэн байсныг долдугаар сарын 1-нээс эхлэн 8,5 болгон бууруулж, сайн дураар даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээг 12,5 хувь байсныг 11,5 хувиас багагүй байх зохицуулалт хийлээ. Ингэснээр даатгуулагчийн орлого дунджаар 10 орчим хувиар өснө. Ингэснээр цар тахлын үед байгууллага, аж ахуйн нэгжид очих дарамт багасах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажлын байраа хадгалах, иргэдийн бодит орлого нэмэгдэх боломжийг бүрдүүллээ.

Арван найман нас хүртэлх 1,2 сая хүүхдэд сар бүр олгож байгаа 100 мянган төгрөгийн тэтгэмж, 71 мянган иргэнд олгож буй халамжийн нэмэгдэл, мөн иргэд, аж ахуйн нэгжийн хэрэглэсэн цахилгаан, дулаан, цэвэр бохир усны зардлыг төрөөс хариуцаж байгааг он дуустал үргэлжлүүлэхээр шийдвэрлэлээ. Мөн 2021 оны төсөвт тодотгол хийж, цар тахлын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангахад шаардлагатай санхүүжилтийн нэмэлт эх үүсвэрийг төсвийн тодотголд тусгалаа. Нийтдээ 743 тэрбум төгрөгөөр эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг нэмэгдүүлсэн. Үүн дотор цалин хөлсөө нэмэгдүүлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж авах бүрэн боломжийг бүрдүүлж өгсөн.

Хөдөө аж ахуй, түүний дотор газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих үүднээс шинэ трактор, комбайн, машин механизм, усалгаа, хүлэмжийн, түүнчлэн ойн болон шувууны аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж, хөнгөллөө. Банкны зээлийн хүүг үе шаттай бууруулах бодлого амжилттай хэрэгжиж байна. Энэ зорилгоор Банк, эрх

бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг шинээр баталлаа. 10 их наядын эдийн засгийг дэмжих хөтөлбөрийг Монголбанк амжилттай хэрэгжүүлж байна. Бизнес эрхлэлтийг дэмжих үүднээс 72 мянган иргэн, аж ахуйн нэгжийн Монголбанкин дахь зээлийн мэдээллийн хар түүхийг хаалаа. Түүнчлэн зээлээ төлж дууссан ч гэсэн урьд өмнө авсан зээлийн төлөлт муу байснаар хар жагсаалтад орсон аж ахуйн нэгжүүдийг энэ тохируулгад хамрагдаж байгаа юм. Зээлээ төлсөн мөртөө зээлийн түүх нь хар болж үлдсэн улсуудыг.

Энэ удаагийн чуулган соёл урлагийн салбараа шинэ нөхцөлд сэргээн хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулсан чуулган боллоо. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хийж баталлаа. Монгол Улсын түүхэнд анх удаа Кино урлагийг дэмжих тухай хуулийг баталлаа. Монголын соёлын давтагдашгүй хэв шинжийг тодорхойлох, хамгаалах хүрээнд төрөөс тусгайлан дэмжлэг үзүүлэх, соёлын үйл ажиллагааны чиглэлийг тодотгон, соёл судлал, соёлын боловсролын үйл ажиллагааг өргөжүүлэх, соёлын үнэт зүйлийн бүртгэл, үнэлгээний болон соёлын бүтээлч үйлдвэрлэлийн асуудлыг зохицуулах эрх зүйн үндэс ийнхүү бүрдлээ. Төрөөс кино урлагийг дэмжих бодлого нь ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, шударга, ойлгомжтой, энгийн байх зарчмыг тогтоож, уран бүтээлчийн хөгжлийг дэмжих, кино үйлдвэрлэлд шаардагдах дэд бүтцийг бий болгох, кино урлагийн мэдээллийн сан бүрдүүлэх, кино урлагаар дамжуулан түүх, өв соёлоо дэлхийд сурталчлан таниулах зэрэг зохицуулалтууд Кино урлагийг дэмжих тухай хуульд тусгалаа олсон.

Эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурал цар тахлаас иргэдээ хамгаалах, эдийн засгаа дэмжихтэй холбоотой тулгамдсан асуудлыг тухай бүр шуурхай авч хэлэлцэж, шаардлагатай шийдвэрүүдийг гаргаж ирлээ. Халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжих хугацааг хоёр удаа сунгаж, Засгийн газрын нөөц хөрөнгийн болон Эрүүл мэндийн даатгалын сангийн зардлыг захиран зарцуулалтыг шуурхай зохицуулахтай холбоотой зарим нэмэлт, өөрчлөлтийг оруулж Засгийн газарт ажиллах боломжийг олгосон. Улсын Их Хурал Монгол Улсын 2020 оны нэгдсэн төсвийн тайланг авч хэлэлцэн, 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг шинэчлэн найруулж, Монгол Улсын хөгжлийн 2022 оны жилийн төлөвлөгөөг баталлаа.

Энэ оны улс төрийн чухал үйл явдал бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль байлаа. Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу 6 жилээр, зөвхөн нэг бүрэн эрхийн хугацаанд ажиллах Ерөнхийлөгчөө сонголоо. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг гээд цаг хугацааны хувьд хүндрэлтэй асуудлууд гарч байсан ч Улсын Их Хурал тухай бүрд нь хуулийн дагуу хэлэлцэн шийдвэрлэж, Төрийн тэргүүний сонгуулийг ямар нэгэн саадгүй явуулах эрх зүйн орчныг бүрэн бүрдүүлж ажилласан. Бүх ард түмний санал хураалтаар олонхын санал авсан Ухнаагийн Хүрэлсүхийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж, бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хууль баталж, Улсын Их Хуралд тангараг өргөх ёслолын арга хэмжээг зохион байгууллаа. Ийнхүү Монгол Улсын шинээр сонгогдсон Төрийн тэргүүн бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлээд байна.

Эрхэм гишүүд ээ,

Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүрэн утгаар нь мөрдүүлэх, энэ оны эхээр баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийг бүрэн хэрэгжүүлэх нь бидний үндсэн зорилго юм. Эрх зүйн хувьсгалыг эрчимтэй өрнүүлэх зорилт маань нэн чухал, томоохон хуулиудын төслүүдийг боловсруулах, өргөн мэдүүлэх, хэлэлцэж батлах, мөрдүүлж хэрэгжүүлэх гээд үе шат бүр жигд явагдах ёстой. Төслүүдийг цаг алдалгүй, үндэслэл сайтай, чанартай, харилцан уялдаатай боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хуулийг хэрэгжүүлэхэд холбогдох байгууллагууд Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам онцгой анхаарах шаардлагатай байна. Энэ ажилд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хорооны зүгээс хяналт тавьж ажиллахыг үүрэг болгож байна. Ирэх намрын чуулганаар энэ эрх зүйн хувьсгалаа бид төгс төгөлдөр хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хэдийгээр халдвар хамгаалал, хорио цээрийн дэглэм баримтлах шаардлагатай байгаа ч чуулганы завсарлагааны хугацаанд цахим парламентын сүлжээ, техник технологийн боломж, бусад бололцоотой арга хэрэгслийг ашиглан батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд хүргэж ойлгуулах, намрын чуулганаар хэлэлцэхээр төлөвлөсөн хуулиудаар нээлттэй хэлэлцүүлэг цахимаар зохион байгуулж, иргэд сонгогчдын саналыг тусгах чиглэлээр идэвхтэй ажиллахыг Улсын Их Хурлын гишүүддээ чиглэл болгож байна.

Элэг нэгт Монголчууд, эрхэм гишүүд та бүхэндээ Ардын хувьсгалын 100 жилийн ойн мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын 2021 оны хаврын чуулган өндөрлөснийг мэдэгдье.

Дууны бичлэгээс буулгасан:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ